МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР
ПАРЛАМЕНТЫН СУДАЛГАА,
ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭН

“ИРГЭДИЙН УЛС ТӨРИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫН ЗУРАГЛАЛ, УЛС ТӨРИЙН ИДЭВХ ОРОЛЦОО, ОЙЛГОЛТ, МЭДЛЭГИЙГ ТОДОРХОЙЛОХ СУДАЛГАА”

Судалгааны төрөл: **Социологийн судалгаа**
Судалгааны код: **БГСТ-24/047**

ЗАХИАЛАГЧ: Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэн

ГҮЙЦЭТГЭГЧ: Цогц хөгжлийн үндэсний төв

Улаанбаатар хот
2024

“Иргэдийн улс төрийн үзэл баримтлалын зураглал, улс төрийн идэвх оролцоо, ойлголт мэдлэгийг тодорхойлох судалгаа”-г “**Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэн**”-гийн захиалгаар **“Цогц Хөгжлийн Үндэсний Төв”**-ийн судалгааны баг гүйцэтгэсэн болно. Судалгааны тайланд илэрхийлсэн үзэл санаа, дүгнэлт, зөвлөмж нь Парламентын судалгаа хөгжлийн хүрээлэнгийн албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

СУДАЛГААНЫ БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН:

СУДАЛГААНЫ БАГИЙН ГИШҮҮД

М.Энхбадрал, Социологийн магистр

Э.Гэрэлт-Од, Улс төр судлалын доктор

Г.Доржтүвдэн, Социологич

Ж.Батболд, Социологич

Ц.Ононтуул, судлаач

contact@nccd.mn
2024 он

АГУУЛГА

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ 3
НЭГ. УДИРТГАЛ 6
Судалгааны үндэслэл 6
Онолын үндэс 7
Судалгааны арга зүй 10
Судалгаанд оролцогчдын хүн ам зүйн мэдээлэл 14
ХОЁР. УЛС ТӨРИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫН ТАЛААРХ ТОВЧ ТАЙЛБАР 17
Үзэл баримтлал гэж юу вэ? 17
Гурван үзэл баримтлалын үндсэн зарчмууд 19
Улс төрийн үзэл баримтлалыг харьцуулах нь 24
Нийгмийн болон соёлын асуудалд хандах байдал 26
ГУРАВ. ИРГЭДИЙН УЛС ТӨРИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ: ТӨСӨӨЛӨЛ БА БОДИТ БАЙДАЛ 29
ДӨРӨВ. НИЙГМИЙН ИНСТИТУТҮҮДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ ИРГЭДИЙН БАЙР СУУРЬ БА УЛС ТӨРИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ 36
ТАВ. МОНГОЛЫН УЛС ТӨРИЙН НАМУУДЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ 50
Монголын улс төрийн намуудын үзэл баримтлал 50
Намын түүх, үүсэл, хөгжил 51
Намын үйл ажиллагаа болон гишүүдийн байр суурь 62
ДҮГНЭЛТ 64
НОМ ЗҮЙ 67

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.Тоон судалгааны түүвэр 13
Хүснэгт 2. Фокус бүлгийн ярилцлагын түүвэр 13
Хүснэгт 3. Судалгаанд оролцогчдын нас, хүйсийн харьцаа 14
Хүснэгт 4. Улс төрийн үзэл баримтлалын харьцуулалт: Эдийн засгийн бодлогод..... 25
Хүснэгт 5. Улс төрийн үзэл баримтлалын харьцуулалт: Нийгэм соёлын асуулалд..... 28
Хүснэгт 6. Улс төрийн үзэл баримтлалын хүснэгт 29
Хүснэгт 7. Бүлэг асуудал тус бүрд давамгайлсан үзэл баримтлал..... 36
Хүснэгт 8. Нийгмийн голлох салбарын асуудал тус бүрд хандах ялгаатай, давамгайлах байр суурь..... 37
Хүснэгт 9. УИХ-д суудалтай намуудын үүсэл хөгжил 53
Хүснэгт 10. Намуудын эрхэм үзэл баримтлал, эрх зорилго..... 54
Хүснэгт 11. МАН-ын сонгуулийн мөрийн хөтөлбөр (УИХ-ын 2024 оны ээлжит сонгууль)..... 56
Хүснэгт 12. АН-ын сонгуулийн мөрийн хөтөлбөр (УИХ-ын 2024 оны ээлжит сонгууль) 57
Хүснэгт 13. Үндэсний эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөр (УИХ-ын 2024 оны ээлжит сонгууль) 58
Хүснэгт 14. ИЗНН-ын сонгуулийн мөрийн хөтөлбөр (УИХ-ын 2024 оны ээлжит сонгууль)..... 59
Хүснэгт 15. ХҮН намын сонгуулийн мөрийн хөтөлбөр (УИХ-ын 2024 оны ээлжит сонгууль)..... 60

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 1. Судалгаанд оролцогчдын байршил, хот хөдөөгөөр (хувиар) 14
График 2. Хөдөө орон нутгаас судалгаанд оролцогчдын байршил, бүсчлэлээр 15
График 3. Боловсролын түвшин (хувиар).....15
График 4. Хөдөлмөр эрхлэлтийн байдал (хувиар) 16
График 5. Орлогын түвшин (хувиар) 16
График 6. Өөрийгөө нийгмийн давхаргад хамааруулсан байдал (хувиар) 16
График 7. Иргэдийн улс төрийн үзэл баримтлалын тойм 30
График 8. Улс төрийн үзэл баримтлал, хүйсээр 30
График 9. Улс төрийн үзэл баримтлал, насны бүлгээр 31
График 10. Улс төрийн үзэл баримтлал, боловсролын түвшнээр 31
График 11. Улс төрийн үзэл баримтлал, орлогын түвшнээр 32
График 12. Улс төрийн үзэл баримтлал, хот хөдөөгөөр 32
График 13. Улс төрийн үзэл баримтлал, хөдөлмөр эрхлэлтийн байдлаар 33
График 14. Иргэд өөрийн улс төрийн үзэл баримтлалыг тодорхойлсон байдал (хувиар)34
График 15. Иргэдийн өөрийгөө тодорхойлсон улс төрийн үзэл баримтлалыг бодит байдалтай харьцуулсан нь.....34
График 16. Төрөөс хэвлэл мэдээлэл, нийгмийн сүлжээнд хяналт тавих ёстой гэдэгтэй санал нийлэх эсэх, улс төрийн үзэл баримтлалаар 38
График 17. Жендерийн тэгш байдлыг хангахад төр оролцох ёстой гэдэгтэй санал нийлэх эсэх, улс төрийн үзэл баримтлалаар.....38
График 18.Төр засаг ажилгүйдлийг бууруулах үүрэгтэй эсэх, улс төрийн үзэл баримтлалаар 38
График 19. Төр засаг, өмчтэй үйлдвэрлэлтэй байх эсэхэд иргэдийн байр суурь.....39
График 20. Эдийн засаг дахь төрийн оролцооны талаарх байр суурь (хувиар).....39
График 21. Төрийн байгууллагын хүний нөөцийн асуудлаарх иргэдийн байр суурь, улс төрийн үзэл баримтлалаар 40
График 22. Төр засаг нийгмийн баялгийн талаар баримтлах бодлого, улс төрийн үзэл баримтлалаар 41
График 23. Эрүүл мэндийн үйлчилгээний талаарх олон нийтийн байр суурь (хувиар) ...42
График 24. Эрүүл мэндийн үйлчилгээний талаарх байр суурь, улс төрийн үзэл баримтлалаар 43
График 25. Боловсролын үйлчилгээний талаарх олон нийтийн байр суурь (хувиар) 43
График 26. Боловсролын үйлчилгээний талаарх байр суурь, улс төрийн үзэл баримтлалаар 44
График 27. Хүний эрхийн үзүүлэлтийн үнэлгээ (0-5 оноогоор).....45
График 28. Хүний эрхийн талаарх байр суурь, улс төрийн үзэл баримтлалаар 46
График 29. Гэр бүлийн амьдралын талаарх байр суурь 46
График 30. Ижил хүйстний гэрлэлтийн талаарх иргэдийн санал бодол, насны бүлгээр ..47
График 31. Байгаль орчныг хамгаалах бодлогын талаарх байр суурь (хувиар).....47
График 32. Гаднын улсын иргэдийг хүлээн авах тал дээр иргэдийн байр суурь (хувиар) 48

НЭГ. УДИРТГАЛ

Судалгааны үндэслэл

Иргэдийн улс төрийн үзэл баримтлалыг тодорхойлох судалгаа нь үндэсний хэмжээнд улс төрийн орчин, улс төрийн намын нөхцөл байдал, хөгжлийн хандлагыг судлах чухал арга хэрэгсэл юм. Уг судалгаа нь иргэдийн улс төрийн оролцоо, санал бодол, хандлага, үнэт зүйлсийн өөрчлөлтийг хэмжих суурь болох боломжтой.

Иргэдийн улс төрийн үзэл баримтлал, хандлага, сонголт нь улс төрийн оролцоог нөхцөлдүүлэх хүчин зүйл болохын хувьд сонгууль, хуулийн хэрэгжилт, төрийн бодлогод мөн үлэмж нөлөөлдөг. Иргэдийн улс төрийн үзэл баримтлал нь нийгэм, эдийн засгийн болон соёлын өөрчлөлттэй холбоотой байдаг. Тиймээс уг судалгаагаар эдгээр өөрчлөлтийн үед, иргэдийн ойлголт, хандлага хэрхэн хөгжиж байгааг тодорхойлж болох юм. Улс төрийн үзэл баримтлал, түүний өөрчлөлт нь нийгмийн тогтвортой байдалд нөлөөлөх тул уг судалгааг ашиглан, засгийн газрын бодлого, стратегийг сайжруулах боломжтой.

Иргэдийн улс төрийн үзэл баримтлалыг судалснаар сонгогчийн боловсролыг сайжруулах арга замыг тодруулах боломжтой бөгөөд иргэдийн мэдээлэлтэй, утга учиртай оролцоог дэмжих, улс төрийн идэвхийг нэмэгдүүлэх боломж бүрдэнэ. Цаашлаад уг судалгаа нь зөвхөн иргэдийн үзэл бодлыг тодруулах бус улс төрийн институтүүдийн чадавхыг хэмжих, тэр дундаа улс төрийн намын хөгжилд чухал ач холбогдолтой мэдээлэл болох юм.

Онолын үндэс

Ардчилсан тогтолцоо нь төрөөс аль нэг үзэл суртлыг албан ёсны улс төрийн үзэл суртлаар зарладаггүй, харин иргэд бүсдаас ялгарах улс төрийн сонирхол, үнэт зүйлсээрээ эвлэлдэн нэгдэж, зорилго, үйл ажиллагаандаа баримтлах зарчим, үнэт зүйлийг тодорхойлж, улс төрийн бусад намуудтай өрсөлдөх нь ардчиллын олон ишт тулгуур юм.

Улс төрийн шинжлэх ухаанд намыг төрийн эрх мэдлийг олж авах, хэрэгжүүлэх сонирхолтой эвлэлдэн нэгдсэн бүлэг хүмүүс[1] гэж үздэг бол үзэл суртлыг тодорхой сонирхолтой бүлэг, тэр дундаа нам үйл ажиллагаандаа баримтлах үнэт зүйл, зарчмуудын цогц[2] гэж тодорхойлдог. Тэгэхээр хүний эрх, олон ургалч үзлийг зөвшөөрсөн улс оронд улс төрийн нам байгуулж байгаа иргэдийг нэгтгэсэн зорилго, тэрхүү зорилгодоо хүрэх үйл ажиллагааг системчилсэн үзэл суртал зайлшгүй байх ёстой. Хэрэв өөрсдийгөө ямар нэг үзэл суртлыг баримталдаггүй гэж байгаа бол энэ нь үзэл суртлыг үгүйсгэсэн үзэл сурталч байж болох юм.

Үзэл суртал нь улс төрийн нам засгийн газар байгуулах, эсхүл сөрөг хүчний чиг үүргийг хэрэгжүүлэх замаар улс төрийн эрх мэдлээ хэрэгжүүлэхэд баримтлах бодлогыг тодорхойлоход чухал үүрэг гүйцэтгэдэг. Өөрөөр хэлбэл, намын бодлого, үйл ажиллагааг системчилж өгөх, үнэт зүйлсээ тууштай хадгалахад дэмжих хөшүүрэг болдог учраас нам бүр өөрийн үзэл сурталтай байдаг. Тиймдээ ч анх XVIII зууны Францын сэтгэгч Дестют де Траси үзэл суртлыг “үзэл санаануудын тухай шинжлэх ухаан” гэж нэрлэж байсан. Энэ үзэл санааг амилуулдаг институц бол улс төрийн нам.

Улс төрийн нам ямар үзэл суртлыг сонгож байгаагаар нь ангилах хандлага анх нам үүсэж байхад л эхэлсэн, одоо ч үнэ цэнээ алдаагүй байсаар байна. Тиймээс намуудыг улс төрийн парадигмаар нь ***барууны, зүүний*** гэж ангилна.

[1] Britannica encyclopedia. https://www.britannica.com/topic/political-party
[2] Идеологи. https://mn.wikipedia.org/wiki/%D0%98%D0%B4%D0%B5%D0%BE%D0%BB%D0%BE%D0%B3%D0%B8

Барууны, зүүний үзэл суртлын үнэт зүйлсийн анхны ялгаа[3]

Зүүний үзэл суртал	Барууны үзэл суртал
• Эрх чөлөө • Тэгш байдал • Ах дүүгийн барилдлага • Хүний эрх • Дэвшил • Шинэчлэл • Интернационализм	• Эрх мэдэл • Захирах ёс • Дэг журам • Үүрэг • Уламжлал • Үндэсний үзэл

Дээрх барууны, зүүний үзэл суртлуудыг нарийвчилбал ***фашист, нацист, консерватив, либерал, социалист, коммунист*** гэж ангилдаг. Шугаман тэнхлэг дээр үзэл суртлуудыг байршуулахад барууны зүүн талд, зүүний баруун талд орших үзэл суртлыг төвийн гэж нэрлэдэг. Эхэн үеийн үзэл суртлуудыг сонгодог үзэл суртлууд гэх бөгөөд, хожим нийгмийн хөгжлийг дагаж орчин үеийн үзэл суртлууд болж хувирсан.

Улс төрийн үзэл суртал /спектрум/[4]



Дээрх сонгодог ангилал нь намуудыг төвөөс баруун, төвөөс зүүн чиглэлд шугаман цуваанд байршуулах бөгөөд эдийн засаг дахь төрийн оролцоогоор хэмжинэ. Өөрөөр хэлбэл, барууны үзэл суртлууд нь эдийн засагт төрийн оролцоо бага байх ёстой гэж үздэг бол зүүний үзэл суртлууд нь эдийн засагт төрийн оролцоо их байх ёстой гэсэн хоёр туйлаар хуваагддаг. Орчин үеийн үзэл суртлууд баруунаас төв рүү, зүүнээс төв рүү шилжих хандлага ажиглагдаж байгаа. Мөн эдийн засаг дахь төрийн оролцооноос үүдэн хүний эрх, эрх чөлөөнд хандах хандлага өөрчлөгддөг. Баруун тийш шилжих тусам хүнийг эрх, эрх чөлөөг зөвшөөрдөг бол, зүүн тийш шилжих тусам хүний эрх хязгаарлагддаг. Энэхүү шугаман спектрум нь онолын загварчлал бөгөөд заавал ийм байна гэсэн үг бас биш. Жишээ нь АНУ-ын ардчилсан нам либерал үзэл суртлыг чиг баримжаагаа болгодог

[3] Andrew Heywood. Introduction to Politics. 2005
[4] Political spectrum. https://www.britannica.com/topic/political-spectrum

бөгөөд шугаман спектрум дээр зүүн төвд байршуулдаг. Мөн БНХАУ коммунист улс төрийн тогтолцоотой ч зах зээлийн эдийн засгийг чухалчилдаг.

Орчин үед улс төрийн үзэл суртлыг дээрх сонгодог аргаар тодорхойлохоос гадна хүний эрх, байгаль хамгаалал гэх мэт баруун, зүүн гэсэн шугаман /спектрум/-д үл хамаарах үзэл суртлууд гарч ирсэн нь ***феминизм, экологизм, национализм, глобализм, национализм*** юм. Мөн түүхэнд үзэл сурталгүй байх үзэл суртал үүсэж байсныг мартаж болохгүй. Ямартаа ч улс төрийн нам хэмээх сонирхол нэгтэй бүлэг хүмүүсийг нэгтгэх, улс төрийн зорилгоо хэрэгжүүлэхэд үзэл суртлыг ашигласаар ирсэн, цаашид ч ашигласаар байх нь ойлгомжтой. Гэтэл ямар нэг үзэл суртлыг онцгойлон чухалчилдаггүй, тухайн үеийн нийгэм, улс төрийн хэрэгцээнд тулгуурлаж бодлого, үйл ажиллагаагаа чиглүүлдэг улс төрийн намыг прагматик нам гэж нэрлэх болсон. Энэ нь прагматизм хэмээх үзэлд тулгуурласан улс төрийн нам юм. Судлаач Д.Бумдарь үзэл суртал чанадын утгаараа үгүй болно гэж хэзээ ч байдаггүй. Учир нь хүн төрөлхтний хөгжил, дэвшлийн чиглүүр нь үзэл суртал мөн[5] гэж дүгнэсэн байдаг.

Учир нь улс төрийн нам сонгуульд ялалт байгуулахын тулд иргэдийн итгэлийг олж авах, үнэт зүйлсийг төлөвшүүлэх ажлыг тогтмол хийж байх ёстой бөгөөд үүнд үзэл суртлын үнэ цэнэ оршиж байгаа юм. Гэтэл үзэл суртлыг үл ойшоож улс төрийн зорилгыг биежүүлэх, олон нийтээс дэмжлэг авах жинхэнэ мөн чанарыг хүмүүс ойлгодоггүй. Гэсэн ч сэтгэгчид үзэл суртлын үнэ цэнийг нийгэм, улс төрийн хүрээнд өргөжүүлэн судалсаар ирсэн. Тухайлбал, К.Маркс үзэл суртлын мөн чанарыг эдийн засаг, социал хүчин зүйлтэй холбон тайлбарласан бол Ф.Ницше үзэл суртал нь эдийн засгийн харилцаанаас үл хамаарах соёлын гүнд боловсордог үзэгдэл гэж үзсэн байдаг. К.Мангейм үзэл суртлыг нийгмийн хүчин зүйлс, тэдгээрийн дотроос улс төрийн байр суурьтай нөхцөлдүүлэн судалсан нь үнэ цэнтэй байсаар байгаа.

Үзэл суртал бол намын улс төрийн ашиг сонирхлыг илэрхийлсэн үнэт зүйлсийн цогц гэж өмнө тодорхойлсон. Тиймээс улс төрийн намууд олон нийтийг өөртөө татах, сонгуулиар дэмжлэг авах, дайчлах, зохион байгуулалтад оруулж нэгтгэх хэрэгцээ байнга тулгардаг тул аль нэг нийцтэй үзэл суртлыг хүлээн зөвшөөрөх, эсхүл өрсөлдөгч намын

[5] Political spectrum. https://www.britannica.com/topic/political-spectrum

үзэл суртал, үзэл баримтлалыг эсэргүүцэхэд хэрэглэж ирсэн. Тийм ч учраас улс төрийн намын үзэл суртал бодит байдлыг хамгийн хялбар цэгцтэй томьёолж, олон түмний ухамсар, сэтгэхүйд хүрч ойлгогдох, нөлөөлөх чадвараараа бүхнээс хүчтэй бас бодит байдлыг өөрчлөх зэвсэг болдог. Үзэл суртал яагаад чухал талаар судлаачид дараах дүгнэлтийг хийсэн. [6]

1. Үзэл суртал нийгэм дэх эмх замбараагүй, чиг зүггүй байдлыг цэгцлэх, нийгмийг нэгтгэгч, дайчлагч, тогтворжуулагч үүрэг гүйцэтгэнэ.
2. Үзэл суртал улс төрийн нам, хэсэг бүлгийн үзэл бодол, баримтлал төдийгүй олон түмний ертөнцийг үзэх үзэл, улс төрийн суурь ухамсрыг төлөвшүүлэхэд ихээхэн нөлөөлнө.
3. Үзэл суртал улс төрийн шийдвэр гаргахад тусална.
4. Үзэл суртал олон түмний ухамсарт нөлөөлж, бусадтай хэрхэн харилцах арга замыг ойлгуулж, чиглүүлж өгдөг.

Тиймээс үзэл суртал нь нийтлэг зорилгод хүрэхийн тулд нийгэмд нөлөөлөх, тодорхой системийг бий болгохыг зорьдог бөгөөд улс төрийн нам, бүлэглэлүүдийн үйл ажиллагаанд чухал үүрэг гүйцэтгэдэг ажээ.

Судалгааны арга зүй

Судалгааны хүрээнд анкет асуулгын арга болон фокус бүлгийн ярилцлагын арга мөн баримт бичгийн шинжилгээ хийлээ.

Сонгуулийн насанд хүрсэн иргэдийн дунд үндсэн шалгуур асуултаар улс төрийн үзэл баримтлалыг тодорхойлох зорилгоор тоон судалгаа болон фокус бүлгийн ярилцлагын аргаар судалгааг хийж гүйцэтгэсэн. Тоон судалгаагаар иргэдийн улс төрийн үзэл баримтлалыг тодорхойлохоос гадна улс төрийн идэвх оролцоо, засаглалын талаарх байр суурийг тодорхойлсон.

Улс төрийн намын үзэл суртлыг судлах нь тухайн намын суурь бодлого, үнэт зүйл, зорилго, нийгмийн асуудалд хандах хандлагыг ойлгох чухал үйл явц юм. Энэ судалгаанд

[6] Political spectrum. https://www.britannica.com/topic/political-spectrum

намын үзэл суртлыг үзэл баримтлал хэмээх ухагдахуунтай адил утгаар хэрэглэж байгаа. Тиймээс намын үзэл баримтлалыг тодорхойлохдоо дараах аргуудыг ашиглана. Үүнд:

1. ***Намын түүх, үүсэл, хөгжил.*** Намын түүхийг судалж, нам хэрхэн үүссэн, ямар үзэл баримтлалыг сонгосон, үүний шалтгаан юу болох, түүний хувирлыг судлах шаардлагатай.
2. ***Намын бодлого, баримт бичиг.*** Намын үзэл баримтлал нь ихэвчлэн албан ёсны баримт бичиг (хөтөлбөр, дүрэм, сонгуулийн мөрийн хөтөлбөр)-т хэрхэн тодорхойлсон, тэдгээрийн уялдаа холбоо, бусад намуудаас ялгарах онцлог, зорилгодоо хэрхэн хүрэх тактик бий эсэхийг судлах шаардлагатай.
3. ***Намын үйл ажиллагаа болон гишүүдийн байр суурь.*** Намын удирдлага болон гишүүдийн ил хэлсэн үгс, ярилцлагууд, мөн намын улс төрийн шийдвэрүүд болон түүний хэрэгжилт нь намын үзэл баримтлалтай хэрхэн нийцэж байгааг, мөн олон нийтийн арга хэмжээнүүдэд илэрхийлж буй байр суурь нь тухайн намын үзэл баримтлалыг үнэлэх боломжийг болдог.

Эдгээр арга нь намуудын үзэл баримтлалыг тодорхойлох, бодлого, үйл ажиллагаандаа түсгадаг, тууштай хэрэгжүүлдэг эсэхийг дүгнэх боломжийг олгодог.

Монголын улс төрийн намуудын үзэл баримтлалыг өмнө нь нарийвчлан тодорхойлсон, харьцуулан дүгнэлт, судалгаа байхгүй байна. Тиймээс дээрх аргуудыг ашиглан Монголын улс төрийн намууд ямар үзэл баримтлалтай байгаа, үзэл баримтлалдаа хэр тууштай байдгийг энэ судалгаагаар судлах юм. Гэхдээ энэ чиглэлийн судалгаа нь нэлээд нөөц, хугацаа шаардах тул дараах хязгаарлалтыг хэрэглэлээ.

- УИХ-ын 2024 оны ээлжит сонгуулиар УИХ-д суудалтай болсон улс төрийн 5 намын дүрэм, мөрийн хөтөлбөр, баримт бичиг, холбогдох нээлттэй мэдээллүүдийг судалж дүгнэнэ.
- Дээрх намуудын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг судлахдаа дараах 6 асуудлыг сонгож, намууд хэрхэн зорилт дэвшүүлснээр дүгнэхийг зорилоо. Үүнд: иргэнээс авах татварын асуудал, Их, дээд сургуулийн сургалтын чанарыг сайжруулах асуудал, төрийн албан хаагчдын тооны асуудал, иргэний жагсаж, цуглах эрхийн

асуудал, эрүүл мэндийн даатгал асуудал, экологийн тэнцвэрийг хадгалах асуудлуудыг тус тус харьцуулан судална.

- Намууд дээрх асуудалд төрийн оролцоо, төсвийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлэх үү, эсвэл төрийн оролцоог бууруулах, эрх зүйн орчныг өөрчилж зах зээлийн зарчмаар шийдэх үү зэрэг хэрхэн яаж, ямар тооцоолол хийсэн, тэр бодитой эсэхээр дүгнэнэ.

Судалгааны зорилго

Иргэдийн улс төрийн боловсрол, тэр дундаа улс төрийн нам ба түүний үзэл баримтлалын талаарх ойлголт мэдлэгийг тодорхойлж, тэдний улс төрийн үзэл баримтлалыг тодорхойлох.

Судалгааны хамрах хүрээ

Судалгааны ажлын даалгаварт тусгасны дагуу судлах зүйлийн хүрээг дараах байдлаар тогтов.

Улс төрийн үзэл бариmтлал: Иргэдийн улс төрийн үзэл баримтлалын талаарх ойлголт нь социал демократ, либерал, консерватив үзэл баримтлалын алинд хамаарах эсэхийг тодорхойлно.

Иргэдийн улс төрийн намуудын үзэл баримтлалын талаарх ойлголт нь УИХ-д суудал бүхий МАН, АН, ХҮН намуудыг хамруулаа.

Судалгааны түүвэр

Хүснэгт 1.Тоон судалгааны түүвэр

№	Судалгааны талбар	Түүврийн хэмжээ
1	Улаанбаатар хот	2178
2	Баруун бүс /Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд аймаг/	249
3	Төвийн бүс /Дархан-Уул, Сэлэнгэ, Төв аймаг/	192
4	Зүүн бүс /Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймаг/	117
5	Хангайн бүс /Архангай, Баянхонгор, Өвөрхангай аймаг/	135
6	Хойд бүс /Булган, Орхон, Хөвсгөл аймаг/	216
7	Говийн бүс /Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь аймаг/	150
	Нийт	3237

Хүснэгт 2. Фокус бүлгийн ярилцлагын түүвэр

№	Судалгааны талбар	Ярилцлагын тоо	Түүврийн хэмжээ
1	Улаанбаатар хот	8	48
2	Говь-Алтай /Баруун бүс/	1	6
3	Өмнөговь /Говийн бүс/	1	6
4	Сүхбаатар /Зүүн бүс /	1	6
5	Завхан /Хангайн бүс /	1	6
6	Нийт	12	72

Судалгаанд оролцогчдын хүн ам зүйн мэдээлэл

Судалгааны түүвэр хэсэгт дурдсанчлан уг судалгаанд Монгол улсын насанд хүрсэн 3237 иргэн оролцсон. Уг хэсэгт судалгаанд оролцогчдын хүн ам зүйн мэдээллийг үзүүлэлт тус бүрээр харууллаа.

Хүснэгт 3. Судалгаанд оролцогчдын нас, хүйсийн харьцаа (хувиар)

	25 хүртэлх	26-35	36-45	46-55	56-с дээш	Нийт
Эмэгтэй	12.0	16.9	12.0	7.6	6.1	54.6
Эрэгтэй	7.4	12.4	14.0	6.0	5.6	45.4
Нийт	19.5	29.2	26.0	13.6	11.7	100.0

Судалгаанд хамрагдсан иргэдийн 54.6 хувь нь эмэгтэй, 45.4 хувь нь эрэгтэй хүмүүс байна. Тэдгээрийг насны бүтцээр нь авч үзвэл хамгийн өндөр хувийг буюу 29.2 хувийг 26-35 нас, 26 хувийг 36-45 насны иргэд эзэлж байлаа. Судалгаанд хамрагдсан иргэдийн нас хүйсийн бүтэц нь манай орны хүн амын суваргын ерөнхий бүтэцтэй нийцэж байна.

График 1. Судалгаанд оролцогчдын байршил, хот хөдөөгөөр (хувиар)



Байршлын хувьд нийт судалгаанд хамрагдсан иргэдийн 67.28 хувь нь Улаанбаатар хотод амьдарч байна. Хөдөө орон нутгаас хамрагдсан иргэдийн хувьд 21.96 хувь нь аймгийн төвд амьдардаг.

График 2. Хөдөө орон нутгаас судалгаанд оролцогчдын байршил, бүсчлэлээр (хувиар)



Судалгаанд хамрагдсан иргэдийн 32.7 хувь нь хөдөө орон нутагт амьдарч байна. Тэдгээрийг Монгол улсын “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын 2.1 дэх хэсгийн дагуу зургаан бүст хамруулсан бөгөөд дээрх графикт хамрагдсан иргэдийн эзлэх хувийг харуулав. Хөдөө орон нутгаас хамрагдсан иргэдийн дунд хамгийн өндөр хувийг баруун (Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд аймаг) болон хойд (Булган, Орхон, Хөвсгөл аймаг) бүрдүүлж байлаа.

График 3. Боловсролын түвшин (хувиар)



График 4. Хөдөлмөр эрхлэлтийн байдал (хувиар)

График 5. Орлогын түвшин (хувиар)



ХОЁР. УЛС ТӨРИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫН ТАЛААРХ ТОВЧ ТАЙЛБАР

Улс төрийн үзэл баримтлал нь нийгэмд тулгарч буй асуудлыг хэрхэн тайлбарлах, засаглал удирдлагын бүтцүүдийг хэрхэн зохион байгуулах талаар хэсэг бүлэг хүмүүс болон хувь хүмүүсийн баримталдаг итгэл үнэмшил, үнэт зүйлсийг тодорхойлогч санаа бодлуудын нэгдэл оюуны тогтолцоо юм. Үзэл баримтлал нь улс төрийн үйл ажиллагаа, бодлого боловсруулахад суурь үндэс болдог бөгөөд тэдгээрийн тусламжтайгаар улс төрийн болон нийгмийн олон талт асуудлыг шийдвэрлэх замыг тодорхойлдог.

Түүхийн туршид консерватизм, либерализм, нийгмийн ардчилал буюу социал демократия (social democracy) гэсэн гурван гол үзэл баримтлал нь удирдлагын бүтэц, нийгмийн хөгжлийг чиглүүлж ирсэн. Консерватизм нь уламжлал, тогтвортой байдлыг чухалчилдаг бол либерализм нь хувь хүний эрх чөлөө, тэгш байдлыг дээдэлдэг. Харин нийгмийн ардчилал нь ардчилсан тогтолцоонд нийгмийн шударга ёс, халамжийн зарчмыг хослуулдаг.

Энэхүү онолын хэсэг нь онолын зарчмуудыг ашиглан үзэл баримтлалыг тодорхойлох, тэдгээрийн ялгаатай болон төсөөтэй байдлыг товч байдлаар тайлбарлахыг зорино.

Үзэл баримтлал гэж юу вэ?

Үзэл баримтлал гэдэг нь улс төр, нийгэм, эдийн засгийн асуудлыг хэрхэн ойлгохоос гадна мөн шийдвэрлэх арга замыг тодорхойлдог үзэл бодол, үнэт зүйлсийн цогц тогтолцоо юм. Энэ нь хувь хүн болон хэсэг бүлэг хүмүүсийн улс төр, нийгмийн бодит байдлыг харж буй өнцгийг илэрхийлж, тэдний үйл ажиллагааг чиглүүлэхэд суурь үндэс, чиг болдог. Судлаачид үзэл баримтлалын талаар олон тодорхойлолт дэвшүүлсэн байдаг. Тухайлбал, Австри-Унгарын нэрт социологич Карл Маннхайм олон янзын үзэл баримтлал

нь нийгмийн ялгаатай байдлаас үүсэж бий болдог гэж үзсэн байна.[7] Тэрээр ажилчин болон хөрөнгөтөн давхарга түс бүр өөр өөрсдийн туулсан түүх, туршлага дээр үндэслэн нийтлэг итгэл үнэмшилтэй болдог гэж үзсэн бөгөөд эдгээр давхаргуудын хооронд зөрчилдөөн үүсэх гол шалтгаан нь тэдгээрийн нийгмийн байр сууриас шалтгаалсан ялгаатай итгэл үнэмшил буюу үзэл баримтлал байдаг гэж үздэг.

Италийн философич Антонио Грамши Маннхаймын үзэл санаатай ерөнхийд нь санал нийлэх хэдий ч үзэл баримтлал бол аль нэг бүлэг хүмүүсийн итгэл үнэмшлийн цогц нийлбэрээр зогсохгүй цаашлаад нийгэм дэх удирдагч анги удирдуулж буй ангийг үзэл суртал ба соёлын замаар хянах, сэтгэлгээний хөгжилд нь өөрчлөлт оруулах замаар буюу “соёлын ноёрхлоор” удирдлагыг хэрэгжүүлдэг гэж үздэг.[8] Соёлын ноёрхлыг нийгмийг удирдаж буй анги тогтоосноор нийгэм дэх анги, давхарга хүчний харьцаа болон эрх мэдэл нь нийтлэг ойлголт буюу *common sense* болж удирдаж, удирдуулж буй анги хооронд тогтвортой байдал бий болдог гэж үздэг. Грамшигийн энэхүү санаа нь Карл Маркс болон Фридрих Энгельс нарын дэвшүүлсэн улс төрийн үзэл баримтлал бол “хуурамч ухамсрыг” бий болгодог буюу бодит нөхцөл байдлыг гуйвуулж удирдах гэсэн удирдаж буй ангийн эрх мэдлийн давамгай байдлыг хамгаалахад чиглэдэг[9] гэсэн санааг үргэлжлүүлэн дэлгэрүүлэх болжээ.

Улс төрийн үзэл баримтлалын үүсэл, хөгжил нь түүхийн тодорхой цаг үеийн өөрчлөлтүүдтэй нягт холбоотой байдаг. Тухайлбал, консерватизм нь 18-р зуунд Францын хувьсгалыг эсэргүүцэн үүссэн бөгөөд нийгмийн тогтвортой байдлыг хамгаалж, өөрчлөлтийг аажим, органик байдлаар хийхийг чухалчилдаг. Харин либерализм нь хувь хүний эрх, эрх чөлөө, тэгш байдал зэрэг Сэргэн мандалтын үеийн үзэл санаан дээр тулгуурлан хөгжсөн. Нийгмийн ардчилал нь 19-р зууны сүүл үеэс капитализмын тэгш бус байдлыг арилгах зорилгоор үүссэн бөгөөд энэ нь ардчилсан тогтолцоог нийгмийн шударга ёс, халамжийн бодлоготой хослуулсан үзэл баримтлал юм.

[7] Mannheim, Karl. *Ideology and Utopia: An Introduction to the Sociology of Knowledge.* Harcourt, 1936.
[8] Gramsci, Antonio. Quaderni del carcere. 1929
[9] Eyerman, Ron. False Consciousness and Ideology in Marxist Theory. *Acta Sociologica*, vol. 24, no. 1/2, 1981, pp. 43–56.

Эдгээр үзэл баримтлалууд нь цаг хугацааны явцад хувьсан өөрчлөгдөж, олон салбар үзэл баримтлалууд бий болж өнөөгийн улс төр, эдийн засаг, нийгэмд тулгарч буй асуудлыг тодорхойлох болон шийдвэрлэхэд өөр өөрсдийн гарц, шийдлийг дэвшүүлж байна.

Гурван үзэл баримтлалын үндсэн зарчмууд

1. Консерватизм

Консерватизм гэдэг нь уламжлалт үнэт зүйлс, эрх мэдэл, нийгмийн тогтвортой байдлыг чухалчилсан улс төр, нийгмийн үзэл баримтлал юм. Энэ үзэл баримтлал нь нийгмийн өөрчлөлт нь органик, аажмаар явагдах ёстой гэж үздэг бөгөөд гэнэтийн, эрс өөрчлөлт нь нийгэмд тогтворгүй байдал үүсгэж болзошгүй гэж анхааруулдаг. Консерватив үзэл нь Францын хувьсгалын үеэс эхлэлтэй бөгөөд 18-р зууны философич Эдмунд Беркийн *Reflections on the Revolution in France* бүтээлд гол үндэс суурь нь тавигдсан гэж үздэг.[10] Берк хувьсгалын гэнэтийн өөрчлөлтийг эсэргүүцэж, нийгмийн залгамж чанар, соёлын уламжлалыг хадгалахыг уриалж байв.

Уламжлал нь консерватив үзэл баримтлалын гол тулгуур юм. Энэ нь гэр бүл, шашин, засаглалын байгууллага зэрэг нийгмийн үндсэн институтүүдийг хамгаалах замаар тэдгээрийг хөгжүүлэх шаардлагыг онцолно. Консерватив үзэл баримтлалын дэмжигчид эдгээр институтүүдийг нийгэмд тогтвортой байдал, ёс суртахууны чиглэл өгөх үүрэгтэй гэж үздэг. Түүнчлэн, тэд соёлын уламжлалыг хадгалах нь ирээдүйд нийгмийн тогтвортой байдлыг хангахад чухал ач холбогдолтой гэж үздэг.

Эрх мэдэл нь консерватив үзэл баримтлалд мөн чухал байр суурь эзэлдэг. Консерватив онолчид засаглалын эрх мэдэл нь нийгмийн дэг журмыг хадгалах, хууль сахиулах үүрэгтэй гэж үздэг бөгөөд үүнийг улс төрийн дээд албан тушаалтнууд болон уламжлалт институтүүдээр дамжуулан хэрэгжүүлэх ёстой гэж үздэг. Беркийн үзэл санаа

[10] Burke, Edmund. *Reflections on the French Revolution.* 1790

нь зөвхөн Английн уламжлалт засаглалд төдийгүй орчин үеийн барууны ардчилсан улс төрийн хөдөлгөөнүүдэд ч нөлөөлсөөр ирсэн.

Консерватив засгийн газарт төрийн оролцоо нь тодорхой хүрээнд хязгаарлагдмал байх хандлагатай ч нийгмийн тогтвортой байдал, уламжлал, үндэсний аюулгүй байдлыг хамгаалахад чухал үүрэгтэй гэж үздэг. Консерватив үзэл баримтлалын хувьд төрийн оролцоо нь эдийн засгийн болон нийгмийн тэгш бус байдлыг шийдвэрлэхээс илүүтэйгээр дэг журам, эрх мэдлийн тэнцвэрийг хадгалах, үндэсний ашиг сонирхлыг хамгаалахад чиглэдэг.

Эцэст нь, тогтвортой байдал бол консерватив үзэл баримтлалын өөр нэг чухал элемент юм. Энэ үзэл баримтлал нь нийгмийн гэнэтийн, хүчтэй өөрчлөлт нь зөвхөн эмх замбараагүй байдал, сүйрэлд хүргэж болохыг анхааруулдаг. Тиймээс тэд шинэчлэл, өөрчлөлтийг аль болох хяналттай, аажим явагдах ёстой гэж үздэг.

2. Либерализм

Либерализм бол хувь хүний эрх чөлөө, тэгш байдал, хязгаарлагдмал засаглалыг чухалчилсан үзэл баримтлал юм. Энэ нь 17-18-р зуунд Сэргэн мандалтын үеийн философичдын бүтээлээр хөгжсөн бөгөөд Жон Локкийн *Two Treatises of Government* бүтээл либерализмын үндсэн суурийг тавьсан гэж үздэг. Локк хүн бүрийн төрөхөөсөө эрх чөлөөтэй, тэгш байх эрхтэйг тунхаглаж, засаглал нь тэдгээр эрхийг хамгаалах үүрэгтэй гэж онцолсон.[11]

Либерализмд эрх чөлөө нь хамгийн гол байр суурьтай. Хувь хүн өөрийн итгэл үнэмшил, амьдралын хэв маягийг чөлөөтэй сонгох эрхтэй гэж үздэг. Жон Стюарт Миллийн (On Liberty, 1859) бүтээлд либерализм нь хувь хүний эрх чөлөө ба нийгмийн хяналтын хоорондын тэнцвэрийг онцлон тэмдэглэж, төрийн эрх мэдэл нь хувь хүний үйл ажиллагаанд хэт оролцох ёсгүйг дурдсан.

[11] Locke, John. *Two Treatises of Government*. Awnsham Churchill, 1689.

Хувь хүний эрх чөлөөг хамгаалахын тулд засаглал нь хязгаарлагдмал байх ёстой гэж либерализмын үзэл санааг түүчээлэгч Жон Локк 17-р зуунд анх өөрийн бүтээлүүддээ тусгаж байж. Тухайн цаг үед хааны эрх мэдэл хэмжээшгүй бус харин иргэдийн үндсэн эрх болох амьд явах, эрх чөлөөтэй байх, өмчтэй байх гэсэн суурь гурван эрхийг хамгаалахад зорино. Хэрэв төрийн эрх баригч эдгээр эрхийг зөрчвөл нийгмийн гэрээ зөрчигдсөнд тооцогдоно. Ийм тохиолдолд ард иргэд бослого гаргаж, шинэ засгийн газар байгуулах эрхтэй.

Жон Локкийн үзэл санаа өөрийн бүтээлүүдэд тусгагдсанаас хойш 100 хүрэхгүй жилийн дараа Томас Жефферсон түүний онолыг Америкийн Нэгдсэн Улсын Тусгаар тогтнолын тунхаглал бичихдээ гол эх сурвалж болгон ашигласан байдаг.
Тэгш байдал нь либерализмын өөр нэг чухал зарчим юм. Энэ нь бүх хүн хуулийн өмнө адил эрхтэй байх эрх тэгш байдалд тэмүүлэх ёстой гэсэн үзэл баримтлалыг агуулдаг. Аж үйлдвэрийн хувьсгал эрчийг авснаар нийгэмд хөрөнгөтэй, чинээлэг иргэд болон ажилчин ангийн хооронд эдийн засгийн тэгш бус байдал гаарч эхлэхэд Жон Стюарт Милл тэргүүтэй либерал сэтгэгчид төрийн оролцоо нэмэгдэж эдгээр асуудлыг шийдвэрлэж байх ёстой хэмээн үзэж эхлэв.[12] Энэ нь сонгодог либерализмаас орчин цагийн буюу модерн либерализм руу шилжих чухал үе шат болсон бөгөөд нийгмийн шударга ёс, эдийн засгийн зохицуулалт, хамтын халамжийг дэмжих үзэл санааг агуулж эхэлсэн.

Энэ хүрээнд либерализм нь сонгодог язгуур ойлголтоос хувьсан өөрчлөгдөж төр нь нийгэмд шударга ёсыг цогцлоохын тулд зохицуулалт хийх үүрэгтэй гэж үзэх болсон бол үүнд хэсэг бүлэг либерал сэтгэгчид санал зөрөн төрийн оролцоо ямагт минимал буюу байж болох хамгийн бага хэмжээгээр байх ёстой гэсэн зарчимд санал нэгдэн 20-р зууны дунд үед либертари үзэл санааг орчин цагийн либерализмаас ялгах зорилгоор тодорхойлжээ.

[12] Mill, John Stuart. *On Liberty.* J.W. Parker and Son, 1859.

Фридрих Хайек[13], Милтон Фридман[14], Айн Рэнд[15] зэрэг эдийн засагч, философичдын бүтээлүүдээр либертари үзэл түгэн дэлгэрсэн. Төрийн үүргийг хамгийн бага түвшинд байлгах, хувь хүмүүс өөрсдийн амьдралаа төрөөс хараат бусаар бүрэн удирдах эрхтэй байх нь нийгэм, эдийн засагт хамгийн их үр ашиг өгөх бөгөөд шударга ёс хангагдана гэж либертари үзэлтнүүд үздэг.

3. Нийгмийн ардчилал

Нийгмийн ардчилал нь 19-р зууны сүүл, 20-р зууны эхэн үеэс эхлэн социализмын доторх шинэчлэгч хөдөлгөөн хэлбэрээр үүссэн. Энэ нь аж үйлдвэрийн капитализмаас үүдэлтэй тэгш бус байдал, шударга бус байдлыг арилгах зорилготой байв. Марксист үзэл санаанд суурилсан ч нийгмийн ардчилал хувьсгалт социализмаас салж, хүчирхийлэлд тулгуурласан хувьсгалын оронд ардчилсан арга замаар өөрчлөлт хийхийг зорьдог. Нийгмийн ардчилал бол эдийн засгийн тэгш байдлыг ардчилсан засаглалтай хослуулж, нийгмийн шударга ёсыг хангахыг зорьдог үзэл баримтлал юм. Энэ нь 19-р зууны сүүл үед социализмаас салбарлан гарч, Эдуард Бернштейний (Evolutionary Socialism, 1899) бүтээлээр онолын үндэс суур нь тавигдсан. Бернштейний үзлээр капитализмыг бүрэн устгах боломжгүй бөгөөд харин түүнийг ардчилсан дэглэм, институтүүдээр дамжуулан шинэчлэх боломжтой.

Нийгмийн ардчилалд нийгмийн шударга ёс нь хамгийн чухал байр суурийг эзэлдэг бөгөөд эдийн засгийн тэгш бус байдлыг арилгах, ядуурлыг бууруулах, баялгийн хуваарилалтыг шударга хэрэгжүүлэхэд чиглэсэн бодлого хэрэгжүүлэхийг чухалчилдаг. Нийгмийн ардчиллын бодлого нь бүх нийтийн эрүүл мэнд, боловсрол, хүртээмжтэй нийгмийн халамжийн тогтолцоог бий болгохыг зорьдог.

Халамжийн тогтолцоо нь нийгмийн ардчиллын онцлог шинж бөгөөд бүх иргэдийн амьдралын чанарыг сайжруулахад чиглэсэн төрийн үүрэг, хариуцлага гэж үздэг.

---

[13] Hayek, Friedrich A. *The Road to Serfdom*. University of Chicago Press, 1944;
Hayek, Friedrich A. *Law, Legislation, and Liberty: Rules and Order*. University of Chicago Press, 1973.
[14] Friedman, Milton. *Capitalism and Freedom*. University of Chicago Press, 1962.
[15] Rand, Ayn. *The Virtue of Selfishness*. Signet, 1964.

Халамжийн төрийн загвар нь Швед, Норвеги зэрэг Скандинавын орнуудад амжилттай хэрэгжиж, нийгмийн тэгш бус байдлыг бууруулах үр дүнтэй арга зам болж байна.

Ардчилал нь нийгмийн ардчиллын үндсэн тулгуур зарчим бөгөөд төрийн бодлого боловсруулахад иргэдийн оролцоог нэмэгдүүлж, иргэний эрх, эрх чөлөөг баталгаажуулахад чиглэдэг. Нийгмийн ардчилал нь иргэдийн улс төрийн оролцоог хүндэтгэн дээдэлж, тэдний дуу хоолойг сонсох, шийдвэр гаргах үйл явцад тэгш эрхтэйгээр оролцуулахыг чухалчилдаг. Энэ үзэл баримтлал нь ардчиллыг зөвхөн улс төрийн тогтолцооны нэг хэсгээр хязгаарлахгүй, нийгэм, эдийн засгийн бүхий л түвшинд бодитой хэрэгжих ёстой үнэт зарчим гэж үздэг.

Нийгмийн ардчилал нь эдийн засгийн тогтвортой байдал, үр ашгийг нийгмийн тэгш байдлыг хангахтай уялдуулан хослуулахыг зорьдог. Энэ үзэл баримтлал нь холимог эдийн засагт тулгуурладаг бөгөөд чөлөөт зах зээлийн үйл ажиллагааг дэмжихийн зэрэгцээ төрөөс эдийн засагт зохицуулалт хийж, баялгийг дахин хуваарилахыг чухалчилдаг. Нийгмийн ардчиллын бодлогын үндсэн элементүүд нь прогрессив татвар, бүх нийтийн нийгмийн халамжийн тогтолцоо, хөдөлмөрийн эрхийн хамгаалалт юм. Прогрессив татварын бодлогоор өндөр орлоготой иргэдээс илүү их татвар авч, үүнийг нийгмийн халамжийн системийг санхүүжүүлэхэд зарцуулдаг бөгөөд энэ нь баялгийн тэгш бус байдлыг багасгах зорилготой. Бүх нийтийн нийгмийн халамжийн тогтолцоо нь эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлтийн хүртээмжтэй байдлыг хангаж, иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлж, нийгмийн эв нэгдлийг бэхжүүлдэг. Мөн хөдөлмөрчдийн эрхийг хамгаалах, ажлын байрны нөхцөлийг сайжруулах замаар хөдөлмөрийн тогтвортой байдлыг хангадаг. Энэ нь капитализмын сул талуудыг нөхөх, эдийн засгийн бүтцийн өөрчлөлтийг ардчилсан замаар хэрэгжүүлэхийг зорьдог бодитой шийдэл юм.

Нийгмийн ардчилал дахь төрийн оролцоо нь зах зээлийн чөлөөт үйл ажиллагааг хязгаарлахад бус, харин зах зээлийн гажуудлыг засах, нийгмийн тэгш байдлыг хангах, хүн бүрт хүртээмжтэй хөгжлийг бий болгоход чиглэгддэг. Төрийн оролцоо нь нийгмийн болон эдийн засгийн тогтвортой байдлыг хангаж, нийгмийн шударга ёсыг баталгаажуулдаг тул нийгмийн ардчиллын гол тулгуур зарчим юм.

Улс төрийн үзэл баримтлалыг харьцуулах нь

Эдийн засгийн бодлогын талаарх асуудлуудад хандах байдал

Эдийн засгийн бодлого нь улс төрийн үзэл баримтлалын гол тодорхойлогч хэсэг бөгөөд улс орны эдийн засгийн бүтэц, нийгмийн баялгийн хуваарилалт, төрийн оролцооны хэмжээ зэргийг тодорхойлоход чухал үүрэг гүйцэтгэдэг. Консерватизм, либерализм, нийгмийн ардчилал эдийн засгийн бодлогод өөр өөр байр суурь баримталдаг бөгөөд эдгээрийн ялгаа нь тухайн үзэл баримтлалын үндсэн үнэт зүйлс болон нийгмийн өмнө тавьсан зорилготой холбоотой.

Консерватив үзэл баримтлал нь зах зээлийн эдийн засгийн эрх чөлөөг чухалчилдаг боловч нийгмийн тогтвортой байдлыг хангахын тулд төрийн зохих оролцоог шаардлагатай гэж үздэг. Консерватив бодлого нь хувийн өмч, зах зээлийн чөлөөт өрсөлдөөнийг дэмжихийн зэрэгцээ үндэсний аюулгүй байдал, соёлын өвийг хамгаалах, хэтэрхий гэнэтийн эдийн засгийн өөрчлөлтөөс зайлсхийхийг зорьдог. Энэ байр суурь нь зах зээлийн тогтвортой байдлыг хадгалахын тулд төрөөс тодорхой хязгаарлалт, зохицуулалт хийхийг зөвшөөрдөг. Жишээ нь, санхүүгийн хямралаас урьдчилан сэргийлэхийн тулд төрийн зүгээс банк санхүүгийн салбарыг зохицуулах эсвэл стратегийн салбаруудад хяналт тавих зэрэг бодлогыг дэмждэг.

Либерализм нь эдийн засгийн чөлөөт худалдаа, зах зээлийн өрсөлдөөнийг үндсэн зарчим болгож, төрийн оролцоог хязгаарлахыг зорьдог. Либерал үзэл баримтлалд эдийн засгийн өсөлтийг дэмжихийн тулд бизнес эрхлэгчид, аж ахуйн нэгжүүдэд илүү их эрх чөлөө олгохыг шаарддаг бөгөөд зах зээлийн эрэлт, нийлүүлэлт нь нөөцийг үр ашигтай хуваарилах хамгийн үр дүнтэй механизм гэж үздэг. Гэвч орчин үеийн либерализм нь зах зээл дэх хэт давамгайлал, тэгш бус байдлыг багасгахын тулд төрийн зохицуулалтыг тодорхой хэмжээгээр хүлээн зөвшөөрдөг. Жишээлбэл, хөдөлмөрийн зах зээлийг зохицуулах, байгаль орчныг хамгаалах, хэрэглэгчийн эрхийг хамгаалах зэрэг бодлого либерализмын орчин үеийн хэлбэрт багтдаг.

Либерализм анх үүсэж хөгжсөн цагаас хойш нийгэм, эдийн засаг өөрчлөгдөхийн хэрээр төрийн оролцоо ямар ч тохиолдолд үргэлж минимал байх ёстой гэсэн хэсэг бүлэг хүмүүс либертарианизм гэх салбар урсгалыг дагасан байдаг. Либертари үзэлтнүүд эдийн засгийн бүрэн эрх чөлөөг дэмжиж, татвар, зохицуулалт, төрийн халамжийг байж болох хамгийн бага хэмжээнд барихыг зорьдог. Тэд зах зээлийг өөрөө өөрийгөө зохицуулах чадвартай, хамгийн үр ашигтай, шударга систем гэж үздэг.

Нийгмийн ардчилал нь эдийн засгийн бодлогын хувьд хамгийн их төрийн оролцоог шаарддаг үзэл баримтлал юм. Энэ нь баялгийн тэгш бус байдлыг багасгах, нийгмийн сайн сайхан байдлыг хангах зорилгоор баялгийн хуваарилалт, халамжийн бодлогыг тууштай дэмждэг. Нийгмийн ардчилсан бодлогын хувьд төр нь нийгмийн эмзэг бүлгүүдийг хамгаалах, боловсрол, эрүүл мэнд зэрэг бүх нийтийн үйлчилгээг хүртээмжтэй байлгах үүрэгтэй гэж үздэг. Энэ бодлого нь баялгийг дахин хуваарилах, нийгмийн тэгш байдлыг дэмжих, хэт ядуурлыг арилгах замаар иргэдийн амьдралын чанарыг сайжруулахад чиглэдэг.

Хүснэгт 4. Улс төрийн үзэл бариmтлалын харьцуулалт: Эдийн засгийн бодлогод

Улс төрийн үзэл баримтлал	Консерватизм	Либерализм	Нийгмийн ардчилал
Эдийн засгийн философи	Чөлөөт зах зээлийг дэмждэг ч тогтвортой байдал, уламжлалыг хамгаална; огцом өөрчлөлтөөс зайлсхийдэг.	Чөлөөт зах зээл, хувь хүний эрх чөлөөг дээдлэн, төрийн оролцоог хамгийн бага (либертарианизм) эсвэл зохистой хэмжээнд (модерн либерализм) байлгахыг зорьдог.	Зах зээлийг зохицуулах, нийгмийн шударга ёс, тэгш байдлыг дээдэлсэн эдийн засгийн бодлогыг дэмждэг.
Төрийн үүрэг, оролцоо	Хязгаарлагдмал оролцоо, голчлон дэг журам, уламжлал хамгаалах, зах зээлийн тогтвортой байдлыг хангахад чиглэнэ.	Төрийн оролцоо хязгаарлагдмал, зах зээлийн алдаа засах, шударга өрсөлдөөнийг баталгаажуулахад анхаарна.	Зах зээлийг зохицуулах, баялгийг дахин хуваарилах, бүх нийтийн үйлчилгээг хүргэхэд төрийн идэвхтэй оролцоо шаардлагатай.
Баялгийн дахин хуваарилалт	Нийгмийн тогтвортой байдлыг хангахын тулд хязгаарлагдмал дахин хуваарилалт; бүяны үйлсээр (хандив, өргөл, г.м) баялгийг хуваарилахыг илүүд үзнэ.	Тэгш байдлыг хангахын тулд нийгмийн тодорхой нэг хэсэгт хязгаарлагдмал дахин хуваарилалт хийнэ, үр дүнд бус боломжид анхаарна.	Прогрессив татварын бодлогоор баялгийг дахин хуваарилж, нийгмийн шударга байдлыг хангахыг зорьдог.

Улс төрийн үзэл баримтлал	Консерватизм	Либерализм	Нийгмийн ардчилал
Татварын бодлого	Татварын хэмжээ бага; татварын хөнгөлөлтийг тогтмол үзүүлж эдийн засгийн өсөлтийг дэмжинэ.	Татварын хэмжээ бага/дунд байна; нийтийн ашиг тусад чиглэсэн үйлчилгээг санхүүжүүлнэ.	Прогрессив татварыг ашиглан бүх нийтийн үйлчилгээг санхүүжүүлж, тэгш байдлыг зорьдог.
Өсөлт, өөрчлөлт ба тогтвортой байдал	Тогтвортой байдал, аажим шинэчлэлийг тэргүүнд тавьдаг; тогтсон шаталсан бүтэц, иерархийг хамгаалдаг.	Чөлөөт зах зээлийн үр ашиг, инновацад тулгуурлан эдийн засгийн өсөлтийг чухалчилдаг.	Эдийн засгийн өсөлт, тэгш байдлын хоорондын тэнцвэрийг хангахыг зорьдог; хүртээмжтэй өсөлтийг дэмждэг.
Гадаад худалдааны бодлого	Дотоодын үйлдвэрлэл, ажлын байрыг хамгаалах хамгаалалтын бодлогыг дэмждэг; шаардлагатай үед гадны бараа, үйлчилгээнд тариф хэрэгжүүлдэг.	Өрсөлдөөн, инновац, дэлхийн эдийн засгийн интеграцчилалыг нэмэгдүүлэхийн тулд чөлөөт худалдааг дэмждэг.	Ажилчдын эрхийг хамгаалж, байгаль орчны стандартыг хадгалах, тэгш боломж бүхий эдийн засгийн өсөлтийг дэмжих худалдааны бодлогыг тэргүүнд тавьдаг.

Нийгмийн болон соёлын асуудалд хандах байдал

Консерватизм, либерализм, нийгмийн ардчиллын нийгмийн болон соёлын үзэл баримтлал нь тэдний суурь философиос хамааран өөр хоорондоо ялгаатай бөгөөд энэ нь уламжлал, хувь хүний эрх, нийгмийн үнэт зүйлсэд хэрхэн ханддагаас тодорхой харагддаг. Эдгээр үзэл баримтлалууд нь нийгмийн өөрчлөлтөд хандах хандлага болон нийгэмд ямар асуудлыг тэргүүнд тавьж байгаагаараа ялгардаг.

Консерватизм нь нийгмийн дэг журам, уламжлалыг хадгалах, соёлын өвийг хамгаалахад ихээхэн ач холбогдол өгдөг. Консервативуудын үзэж байгаагаар гэр бүл, шашин, нутгийн хамт олон гэх мэт олон жилийн турш бүрэлдэж тогтсон нийгмийн институтүүд нь нийгмийн тогтвортой байдал, хөгжихийн үндэс суурь болдог. Тэд нийгмийн огцом өөрчлөлтөд эргэлзээтэй хандаж, энэ нь тогтсон үнэт зүйлс, хэм хэмжээг тогтворгүй болгож болзошгүй гэж үздэг. Соёлын өвийн хадгалалт нь нийгмийн эв нэгдлийг хангах чухал хүчин зүйл гэж үздэг тул консерватив бодлого нь уламжлалт гэр бүлийн бүтэц, шашны үнэт зүйлс, үндэсний түүх, онцлогийг бэхжүүлж, дэлгэрүүлэхэд чиглэдэг. Нийгмийн бодлогын хувьд консерватизм нь сахилга бат, хариуцлагыг дэмжиж,

уламжлалт ёс суртахууны хэм хэмжээг бэхжүүлэхэд анхаардаг ба уламжлалт үнэт зүйлсийг өөрчлөх гэсэн аливаа дэвшилтэт хөдөлгөөнд эргэлзээтэй, зарим тохиолдолд эсэргүүцсэн байдлаар ханддаг.

Либерализм нь нийгмийн болон соёлын асуудалд хувь хүний эрх чөлөө, бие даасан байдлыг нэн тэргүүнд чухалчилдаг. Либералууд итгэл үнэмшил, амьдралын хэв маяг, соёлын илэрхийлэл зэрэг нь аливаа төрийн оролцоо эсвэл нийгмийн дарамтаас ангид оршиж, хамтдаа орших ёстой гэсэн олон ургалч үзэлт нийгмийг дэмждэг. Тэд иргэний эрх чөлөөг хамгаалах, ялгаварлан гадуурхалтаас ангид байх нөхцөлийг хангахад онцгойлон анхаардаг. Либерализм нь жендерийн тэгш байдал, ЛГБТК+ эрх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг дэмжих дэвшилтэт нийгмийн бодлоготойгоор холбогддог. Консерватизмаас ялгаатай нь либерализм нийгмийн өөрчлөлтийг нийгмийн жам ёсны хөгжлийн нэг хэсэг гэж үздэг бөгөөд энэ нь хувь хүний эрх чөлөө, боломжийг нэмэгдүүлэх хэрэгсэл хэмээн хүлээн зөвшөөрдөг. Гэхдээ либерализм соёлын томоохон өөрчлөлтийг албадлагаар хэрэгжүүлэхээс илүү хувь хүмүүст өөрсдийн сонголтоо хийх боломж олгохыг чухалчилдаг.

Нийгмийн ардчилал нь хувь хүний эрх чөлөөг дээдлэх либерал үзэл санааг нийгмийн шударга ёс, тэгш байдлыг дэмжих хамтын үйл ажиллагаатай хослуулдаг. Нийгмийн ардчилал нь тэгш бус байдлаас шалтгаалан нийгмийн болон соёлын оролцоо хязгаарлагддагийг засах нь шударга, тэгш нийгмийг бүрдүүлэхэд чухал гэж үздэг. Тэд либералуудын олон ургалч нийгэмд итгэдэг ч төрийн оролцоо илүү чухал гэж үздэг. Тухайлбал, нийгмийн ардчилсан бодлого нь тэгш байдлыг хангахын тулд олон төрлийн төсөл, хөтөлбөрүүд хэрэгжүүлдэг. Жишээ нь нийгмийн эмзэг бүлгийн гишүүдэд чиглэсэн тэдгээрийн чадавхжуулах, соёлын санаачилгыг санхүүжүүлэх, ажиллах орчинд жендерийн тэгш байдлыг хангах хууль тогтоомж зэрэг орно. Нийгмийн ардчилал нь олон ургалч үзэл болон эв санааны нэгдмэл байдлыг дэмжиж соёлыг хувь хүний бус хамтын эрх гэж үздэг.

Хүснэгт 5. Улс төрийн үзэл бариmтлалын харьцуулалт: Нийгэм соёлын асуулалд

Улс төрийн үзэл баримтлал	Консерватизм	Либерализм	Нийгмийн ардчилал
Уламжлалд хандах хандлага	Уламжлал, соёлын өвийг нийгмийн тогтвортой байдал, дэг журмын үндэс гэж үздэг.	Уламжлал нь хувь хүний сонголт, өөрчлөлтөд нийцэж болох зүйл гэж үздэг.	Уламжлалыг хүндэтгэх боловч шударга ёс, тэгш байдлыг хангахын тулд шинэчлэл хийхэд бэлэн байдаг.
Нийгэм дэх өөрчлөлт	Огцом өөрчлөлтөд эргэлзэж, тогтсон хэм хэмжээг хамгаалахын тулд аажим өөрчлөлтийг дэмждэг.	Нийгмийн өөрчлөлтийг хувь хүний эрх чөлөөг өргөжүүлэх байгалийн жам ёсны төдийгүй шаардлагатай зүйл гэж үздэг.	Системийн тэгш бус байдлыг бууруулах, оролцоог нэмэгдүүлэхийн тулд дэвшилтэт өөрчлөлтийг дэмждэг.
ЛГБТК+ эрх	Уламжлалт гэр бүлийн үнэт зүйлсийг хамгаалж, ЛГБТК+ эрхийг хуульчлахад ихэвчлэн эсэргүүцэлтэй ханддаг.	Хувь хүний эрх чөлөө, тэгш байдлын нэг хэсэг болгон ЛГБТК+ эрхийг дэмждэг.	Нийгмийн шударга ёсны хүрээнд ЛГБТК+ эрхийг дэмжиж, бодлогынхоо нэг хэсэг болгодог.
Жендэрийн тэгш байдал	Уламжлалт хүйсийн үүргийг эрхэмлэдэг боловч тогтвортой байдлыг хангахын тулд хязгаарлагдмал арга хэмжээ дэмждэг.	Нийгмийн бүх түвшинд жендерийн тэгш байдал, тэгш боломжийг дэмждэг.	Жендерийн тэгш байдлыг төрөөс хэрэгжүүлдэг бодлого, хөтөлбөртэй хослуулдаг.
Үр хөндөх эрх	Үр хөндөлтийг уламжлалт ёс суртахууны үнэт зүйлсийг зөрчиж байна гэж үзэн эсэргүүцдэг.	Хувь хүний бие махбодын эрх, бие даасан байдлыг чухалчлан үр хөндөх эрхийг дэмждэг.	Үр хөндөх эрхийг эрүүл мэндийн үндсэн үйлчилгээ, нийгмийн шударга ёсны нэг хэсэг гэж үздэг.
Шашин	Соёл, ёс суртахууны амьдралын төвд шашны үүргийг дэмжиж, шашны боловсролыг чухалчилдаг.	Шашин нь төрийн бодлого, засаглалд оролцохгүй байхыг баталгаажуулсан секуляризмийг дэмждэг.	Шашин нь төрийн бодлого, засаглалд оролцохгүй байхыг баталгаажуулсан секуляризмийг дэмждэг.
Боловсрол	Сахилга бат, ёс суртахуун, үндэсний түүхийг чухалчилсан уламжлалт боловсролыг дэмждэг.	Шүүмжлэлт сэтгэлгээ, олон янз байдлыг хөхиүлэн дэмждэг хүртээмжтэй боловсролыг чухалчилдаг.	Боловсролыг тэгш байдлыг хангах арга хэрэгсэл гэж үзэн эмзэг бүлгүүдэд хүрэх хүртээмжийг нэмэгдүүлэхийг зорьдог.

ГУРАВ. ИРГЭДИЙН УЛС ТӨРИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ: ТӨСӨӨЛӨЛ БА БОДИТ БАЙДАЛ

Иргэдийн улс төрийн үзэл баримтлалыг тодорхойлохдоо нийт үндсэн 7 үзүүлэлт дэд 12 шалгуур үзүүлэлтээр нийгмийн голлох институтийн хүрээнд хувь хүний байр суурийг тодорхойлох асуултаар туршин иргэд тус бүрийн улс төрийн үзэл баримтлалыг тодорхойлов.

Хүснэгт 6. Улс төрийн үзэл бариmтлалын хүснэгт

№	Үндсэн үзүүлэлтүүд	Дэд үзүүлэлтүүд
1	Төрийн зохион байгуулалт	Төр засаг өмчтэй, үйлдвэртэй байх ёстой эсэх
2	Эдийн засаг	Эдийн засаг дахь төрийн оролцоо
		Нийгмийн баялгийн талаар төрийн баримтлах бодлого
		Төр баялгийг тэгш хуваарилах үүрэгтэй эсэх
3	Нийгмийн бодлого	Эрүүл мэндийн үйлчилгээ
		Боловсролын үйлчилгээ
4	Хүний эрх	Хувь хүний эрх нийгмийн аюулгүй байдлаас илүү чухал
		Төр хэвлэл мэдээлэл болон нийгмийн сүлжээнд хяналт тавих эсэх
5	Гэр бүл	Гэр бүлийн амьдралын талаарх байр суурь
6	Байгаль орчин	Байгаль орчныг хамгаалах бодлого
7	Глобал асуудал, цагаачлал, зэвсэг	Гадаадын иргэдийг Монгол улсад цагаачлуулах талаарх байр суурь
		Буу галт зэвсэг эзэмших асуудал

Улс төрийн үзэл баримтлалыг дээрх үзүүлэлтүүдэд хариулсан байдлаар багцлан давамгай байр суурийг тогтоож тухайн иргэний улс төрийн үзэл баримтлал хэмээн тодорхойлсон. Иймд дараах тодорхойлсон улс төрийн үзэл баримтлал нь туйлын, үнэмлэхүй итгэл үнэмшил биш бөгөөд давамгайлагч байр суурь болно.

График 6. Иргэдийн улс төрийн үзэл бариmтлалын тойм



Судалгаанд хамрагдсан иргэдийн 34.2 хувь нь социал демократ, 31.2 хувь нь консерватив, 22.2 хувь нь либерал давамгайлсан улс төрийн үзэл баримтлалтай хэмээн энэхүү судалгааны үр дүнд гарлаа. Харин тус гурван үзэл баримтлалын хувьд адил тэгш шинж чанарыг агуулсан буюу холимог улс төрийн үзэл баримтлалтай иргэд 3.9 хувийг бүрдүүлж байна. Социал демократ болон консерватив 3.8 хувь, социал демократ болон либерал 1.9 хувь, либерал болон консерватив үзэл баримтлалын холимог шинж чанарыг агуулсан иргэд 2.9 хувийг тус тус бүрдүүлж байна.

График 7. Улс төрийн үзэл бариmтлал, хүйсээр



Эрэгтэйчүүд илүү консерватив бол, эмэгтэйчүүдийн хувьд социал демократ үзэл давамгайлж байна. Консерватив үзэл бариmтлалын хувьд хүйсээс хамаарах ялгаатай үр дүн бага ажээ. Эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс илүү либерал үзэл бариmтлалтай байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байна.

График 8. Улс төрийн үзэл бариmтлал, насны бүлгээр



Судалгаанд оролцогчдын нас нэмэгдэх тусам консерватив үзэл баримтлалтай байх нь нэмэгдэж байна. Фокус бүлгийн ярилцлагын явцад иргэд социалист нийгмийн үеийг илүү үйлдвэртэй, хүн бүр ажилтай байсан гэх үндэслэлээр дэмжих нь түгээмэл байсан. Энэ нь уламжлалт, консерватив үзлийг өндөр байхад нөлөөлж байх магадлалтай. Нас залуужих тусам либерал үзлийг дэмжих хандлагатай байгаа ч 35 хүртэлх насны залуучуудын дунд социал демократ үзэл илүү давамгай байгаа нь сонирхолтой үзүүлэлт болж байна.

График 9. Улс төрийн үзэл баримтлал, боловсролын түвшнээр



Шалгуур асуултуудын үр дүнд либерал үзэл баримтлал давамгайлж буй иргэдийн хувьд хүний эрх болон гэр бүлийн амралын талаарх байр суурь нь илүү тэдний либерал болохыг тодотгож байна. Эдгээр хүмүүс нь насны бүлгийн хувьд илүү залуучууд давамгайлсан, боловсролын хувьд дээд боловсролтой байх нь давамгай байна.

График 10. Улс төрийн үзэл бариmтлал, орлогын түвшнээр



Шалгуур асуултуудын үр дүнд социал демократ үзэл баримтлал давамгайлж буй иргэдийн хувьд баялгийн тэгш хуваарилалт, эрүүл мэнд, боловсролын үйлчилгээ зэрэг нийгмийн бодлогод илүү ач холбогдол өгч байна. Судалгаанд оролцсон хүмүүсийн орлогын хэмжээ буурах тусам илүү социал демократ үзэл баримтлал давамгайлж байна. Мөн фокус бүлгийн ярилцлагын үр дүнгээс харахад нийгмийн тэгш байдал, баялгийн тэгш хуваарилалт, хүчтэй төрийг дэмжих нь уг бүлэгт чухал нөлөөтэй байна.

График 11. Улс төрийн үзэл бариmтлал, хот хөдөөгөөр



Судалгаанд хамрагдсан иргэдийн улс төрийн үзэл баримтлалыг амьдарч буй газраар нь харьцуулан дээрх графикт дүрсэллээ. Нийслэл Улаанбаатар хотод амьдарч буй иргэдийн хувьд тус гурван улс төрийн үзэл баримтлалын эзлэх хувь ойролцоо байлаа. Харин аймгийн төвд амьдарч буй иргэдийн хувьд либерал үзэл баримтлалтай иргэдийн эзлэх хувь буурч байсан бол сумын төв болон хөдөө амьдарч буй иргэдийн хувьд социал демократ үзэл баримтлал нь илүү давамгайлж байна. Үүнээс харахад хүн амын нягтаршил буурах тусам иргэдийн дунд социал демократ үзэл баримтлал хүчтэй илэрч байна.

График 12. Улс төрийн үзэл бариmтлал, хөдөлмөр эрхлэлтийн байдлаар



Улс төрийн үзэл баримтлалыг хөдөлмөр эрхлэлтийн салбараар нь харьцуулан дээрх графикт дүрсэллээ. Тус үзүүлэлтээс харахад төрийн байгууллагууд болон малчид, оюутан сурагчдын дунд социал демократ үзэл баримтлал хүчтэй илэрч байлаа. Харин либерал үзэл баримтлал нь хувиараа хөдөлмөр эрхлэгчид, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид болон хувийн секторт ажиллаж буй иргэдийн дунд илүүтэй өндөр байна. Консерватив үзэл баримтлал нь тэтгэврийн болон группийн орлоготой хэсэг, зарим төрийн байгууллагууд, болон хувийн хэвшилд хөдөлмөр эрхлэгчдийн дунд өндөр байна.

Улс төрийн үзэл баримтлалын талаарх иргэдийн өөрсдийн байр суурь

Нийт судалгаанд хамрагдсан иргэдээс өөрийн улс төри йн үзэл баримтлалыг хэрхэн тодорхойлж байгааг нэг асуултаар тодруулахад дараах үр дүн гарлаа.

График 13. Иргэд өөрийн улс төрийн үзэл бариmтлалыг тодорхойлсон байдал (хувиар)



Нийт судалгаанд хамрагдсан иргэдийн талаас илүү хувь нь 52.5 хувь өөрийн улс төрийн үзэл баримтлалыг тодорхойлон хэлж мэдэхгүй байна.

Өөрийгөө улс төрийн аль нэг үзэлд хамааруулж үзсэн иргэдээс хамгийн өндөр буюу 18.2 хувь нь либерал үзэл баримтлалтай, 7.8 хувь нь социал демократ үзэл баримтлалтай гэж хариулсан.

Өөрийн үзэл баримтлалыг хэрхэн тодорхойлсон байдлыг дээрх графикт илэрхийлсэн бол шалгуур асуултаар улс төрийн үзэл баримтлалд хэрхэн ангилагдсан байдлыг дараах графикт харууллаа.

График 14. Иргэдийн өөрийгөө тодорхойлсон улс төрийн үзэл бариmтлалыг бодит байдалтай харьцуулсан нь



Өөрийгөө либерал улс төрийн үзэл баримтлалд хамаатуулан үзэж байсан иргэд судалгааны хамгийн өндөр хувийг буюу 18.2 хувийг бүрдүүлж байсан. Гэсэн хэдий ч судалгааны шалгуур асуултаар либерал үзэл баримтлалд хамаарах иргэд хамгийн бага хувийг бүрдүүлж байсан. Тиймээс тус хариултыг сонгосон иргэдийн шалгуур асуултаар хэрхэн тодорхойлогдож буй байдлыг дээрх графикт харууллаа.

Дээрх графикт босоо баганад өөрийгөө хэрхэн тодорхойлсон байдлыг, хэвтээ баганад шалгуур асуултаар хэрхэн тодорхойлогдсон байдлыг дүрслэн харууллаа. Нэгж судалгаанд оролцогч иргэн бүр аль нэг улс төрийн үзэл баримтлалд шууд хамаарах нь цөөн байлаа. Тухайлбал нийгмийн тодорхой асуудлуудад өөр өөр байр суурийг илэрхийлж байсан нь манай орны иргэдэд улс төрийн туйлын итгэл үнэмшилтэй байдал сул байгааг илэрхийлж байна. Түүнчлэн өөрийгөө аль нэг улс төрийн үзэл баримтлалд хамааруулж үзэж байгаа нь бодит байдалтай тэр бүр нийцэхгүй байгаа нь тогтоогдсон.

ДӨРӨВ. НИЙГМИЙН ИНСТИТУТҮҮДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ ИРГЭДИЙН БАЙР СУУРЬ БА УЛС ТӨРИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Судалгаанд оролцсон иргэд улс төрийн үзэл бариmтлалыг иж бүрэн цогцоор нь баримталдаг бус асуудал тус бүрээс шалтгаалж ялгаатай байр суурь баримталж байна. Үүнийг дараах үзүүлэлтээс харж болно. Тухайлбал судалгаанд оролцогчид хувь хүний эрх, гэр бүлийн харилцаанд либерал давамгай; баялгийн хуваарилалт, нийгмийн үйлчилгээнийх үрээнд социал демократ давамгай; байгаль орчин, эдийн засаг дахь төрийн оролцоо болон цагаачлал, буу зэвсэг эзэмших зэрэг асуудалд консерватив үзэл бариmтлалыг давамгай дэмжиж байна.

Хүснэгт 7. Бүлэг асуудал тус бүрд давамгайлсан үзэл бариmтлал

Либерал	Социал демократ	Консерватив
Хүний эрх Гэр бүлийн харилцаа	Баялгийн хуваарилалт Эрүүл мэндийн үйлчилгээ Боловсролын үйлчилгээ	• Төрийн өмч • Эдийн засаг дахь төрийн оролцоо • Нийгмийн баялаг • Байгаль орчин • Цагаачлал • Зэвсэг эзэмших

Хүснэгт 8. Нийгмийн голлох салбарын асуудал тус бүрд хандах ялгаатай, давамгайлах байр суурь

Үндсэн үзүүлэлт	Дэд үзүүлэлт	Консерватив	Либерал	Социал демократ
Төрийн зохион байгуулалт	Төр засаг өмчтэй, үйлдвэртэй байх ёстой эсэх	36.5%	34.6%	28.9%
Эдийн засаг	Эдийн засаг дахь төрийн оролцоо	45.4%	18.6%	36.0%
	Нийгмийн баялгийн талаар төрийн баримтлах бодлого	54.1%	39.4%	6.5%
	Төр баялгийг тэгш хуваарилах үүрэгтэй эсэх	24.0%	9.2%	66.8%
Нийгмийн бодлого	Эрүүл мэндийн үйлчилгээ	33.0%	16.9%	50.1%
	Боловсролын үйлчилгээ	8.3%	36.7%	55.0%
Хүний эрх	Хувь хүний эрх нийгмийн аюулгүй байдлаас илүү чухал	21.1%	41.1%	37.8%
	Төр хэвлэл мэдээлэл болон нийгмийн сүлжээнд хяналт тавих эсэх	32.5%	39.5%	28.0%
Гэр бүл	Гэр бүлийн амьдралын талаарх байр суурь	11.7%	55.5%	32.8%
Байгаль орчин	Байгаль орчныг хамгаалах бодлого	49.5%	14.1%	36.4%
Цагаачлал	Гадаадын иргэдийн Монгол улсад цагаачлуулах талаарх байр суурь	45.7%	36.1%	18.3%
	Буу галт зэвсэг эзэмших асуудал	51.4%	17.6%	31.0%

Дээрх хүснэгтэд үндсэн долоон шалгуур үзүүлэлт, 12 дэд үзүүлэлтэд эзлэх улс төрийн үзэл баримтлал тус бүрийн эзлэх хувийг харуулав. Судалгаанд хамрагдсан иргэд *төрийн зохион байгуулалт, эдийн засгийн хүчин зүйл, байгаль орчин, цагаачлалын* бодлогын хувьд **консерватив** үзэл баримтлал давамгайлж байлаа.

Харин нийгмийн бодлого буюу нийгмийн үндсэн үйлчилгээ болох *боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний* хувьд **социал демократ** үзэл баримтлалтай байна.

Хүний эрхийн асуудал болон гэр бүлийн харилцааны хувьд **либерал** үзэл баримтлалд түлхүү хамаарч байна.

Үүнээс харахад манай орны иргэд нийгмийн голлох институтүүдийн хувьд баримталж буй байр суурь нь ялгаатай байна. Тиймээс бүхэллэг байдлаараа аль нэг үзэл баримтлалыг тууштай баримтлах байдал манай нийгэмд сул бөгөөд нийгмийн онцлог, түүхэн цаг хугацаанд бүрэлдсэн олон нийтийн сэтгэлгээний хэв шинж, иргэдийн туршлагаас хамаарч харилцан ялгаатай байдал ажиглагдаж байна.

График 15. Төрөөс хэвлэл мэдээлэл, нийгмийн сүлжээнд хяналт тавих ёстой гэдэгтэй санал нийлэх эсэх, улс төрийн үзэл бариmтлалаар (хувиар)



График 16. Жендерийн тэгш байдлыг хангахад төр оролцох ёстой гэдэгтэй санал нийлэх эсэх, улс төрийн үзэл бариmтлалаар



График 17.Төр засаг ажилгүйдлийг бууруулах үүрэгтэй эсэх, улс төрийн үзэл бариmтлалаар (хувиар)



График 18. Төр засаг, өмчтэй үйлдвэрлэлтэй байх эсэхэд иргэдийн байр суурь (хувиар)



Эдийн засгийн тогтолцоо дахь иргэдийн байр суурь

Эдийн засгийн асуудлаар иргэд консерватив байр суурийг баримтлах нь давамгай байлаа. Тухайлбал эдийн засаг дахь төрийн оролцооны талаарх асуудалд дараах байдлаар хариулжээ.

График 19. Эдийн засаг дахь төрийн оролцооны талаарх байр суурь (хувиар)



Шигтгээ 1

Төр эдийн засагт их оролцох нь авлига, хээл хахуулийн үндэс болох эрсдэлтэй. Төрөөс иргэд үйлчилгээ авахаас биш үйлдвэр, аж ахуйн ажлыг хувийн хэвшил гүйцэтгэх нь зүйтэй. Төрийн өмчийн компаниуд ашигтай үйл ажиллагаа явуулдаггүй, тиймээс төр өөрөө үйлдвэртэй байх шаардлагагүй бөгөөд харин хувийн хэвшлийг сайн дэмждэг байх нь чухал. Төрийн зайлшгүй байх ёстой ажлууд нь түлш, эрчим хүч зэрэг цөөхөн салбарууд юм.

Фокус бүлгийн ярилцлагын хэсгээс

График 20. Төрийн байгууллагын хүний нөөцийн асуудлаарх иргэдийн байр суурь, улс төрийн үзэл бариmтлалаар



Чанарын судалгаанд оролцсон төр засгийн байгууллага хүний нөөц аль болох цөөн байх ёстой гэж үзэж байгаа хүмүүсийн хувьд төрийн албан том байснаар төрд ирэх

ачаалал нэмэгддэг, улмаар төсвийн мөнгө их зарцуулж байна гэж үзэх нь нийтлэг байна. Түүнчлэн ажлын байрнуудын хэрэгцээ шаардлагатай эсэхийг тодорхойлох, төрийн албыг цомхон чадварлаг байлгах тал ээр анхаарах нь зүйтэй гэж үзэж байна. Харин төрийн албан хаагчдын тоо төдийлөн хамаатгүй болон төр үүргээ гүйцэтгэхийн тулд төрийн албан хаагч олон байж болно гэж үзэж байгаа хүмүүсийн хувьд төрийн албаны бүтээмжтэй байдалд анхаарлаа хандуулахыг чухалчилж байна.

Шигтгээ 2

Төрийн үйлчилгээ цахимжиж байгаатай холбогдуулан төрийн үйлчилгээний албан хаагчдын тоог цөөлөх боломжтой болсон. Тухайлбал дүүрэг, хороодын төрийн албан хаагчид ихэвчлэн тодорхойлолт олгох зэргээр ажилладаг байсан бол E-mongolia бий болсноос хойш заавал хүний оролцоотой энэ ажлуудыг хийх шаардлага байхгүй болсон. Нөгөө талаасаа төрийн албан хаагчдын цалин амьдралд хүрэлцэхгүй бага хэдий ч олон төрийн албан хаагчдтай тул төсөвт их зардалтай байдаг. Тиймээс төрийн албан хаагчдыг цомхотгож шаардлагагүй албуудыг татан буулгах нь зүйтэй. Төрийн үйлчилгээний албан хаагчдыг цомхон чадвартай байлгах нь чухал. Нөгөөтээгүүр ахмад настнууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг цахимаар үйлчилгээ авах боломжгүй хүмүүст биечлэн үйлчилгээ үзүүлэх нь зүйтэй.

Фокус бүлгийн ярилцлагын хэсгээс

График 21. Төр засаг нийгмийн баялгийн талаар бариmтлах бодлого, улс төрийн үзэл бариmтлалаар



Шигтгээ 3

Судалгаанд оролцсон иргэд төр нийгмийн баялгийг хуваарилах нь зүйтэй гэж үзэж хандлага давамгайлж байлаа. Эрдэнэс таван толгой компанийн ноогдол ашиг хуваарилж байгаа шиг төр нийгмийн баялгийг хуваарилах нь зөв гэж үзлээ. Судалгаанд хамрагдсан зарим хүмүүсийн үзэж байгаагаар нэг хүн хэт их баяжих нь зохисгүй бөгөөд төр нийгмийн баялгийг тэнцүү хуваарилах нь зүйтэй гэх хандлага олон байна.

Фокус бүлгийн ярилцлагын үр дүнгээс

Нийгмийн бодлогын талаарх иргэдийн байр суурь

Нийгмийн бодлогын асуудлаар иргэдийн дийлэнх хувь нь социал демократ үзэл баримтлалд хамаарч байв. Тухайлбал эрүүл мэндийн үйлчилгээний тал дээр судалгаанд хамрагдсан хоёр хүн тутмын нэг нь бүх нийтийн үнэ төлбөргүй үйлчилгээг авахыг илүүд үзэж байлаа.

График 22. Эрүүл мэндийн үйлчилгээний талаарх олон нийтийн байр суурь (хувиар)

График 23. Эрүүл мэндийн үйлчилгээний талаарх байр суурь, улс төрийн үзэл бариmтлалаар



Эрүүл мэндийн үйлчилгээний талаар улс төрийн үзэл бариmтлалаас хамаарч ялгаатай байр суурь илэрч байна. Социал демократ үзэлтэй иргэд төрийн оролцоотой, хүртээмжтэй тогтолцоог илүүд үздэг бол либерал үзэлтэй иргэд зах зээлийн зарчимд тулгуурлахыг дэмждэг. Харин консерватив үзэлтэй иргэдийн дийлэнх нь даатгалын тогтолцоог чухалчилж, хувь хүний үүрэг, хариуцлагыг онцолсон байр суурьтай байна.

График 24. Боловсролын үйлчилгээний талаарх олон нийтийн байр суурь (хувиар)

Судалгаанд оролцсон иргэдийн дийлэнх нь боловсролыг үнэ төлбөргүй, төрийн санхүүжилтээр хангаж, улсын сургуулиудыг голлох байр суурьтай байлгахыг дэмжиж, боловсролын үйлчилгээнд төрийн оролцоо, хяналт шаардлагатай гэж үзэж байна. Харин боловсролын чанарыг нэмэгдүүлэхийн тулд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг дэмжих нь зүйтэй гэж үзсэн. Түүнчлэн судалгаанд оролцогчдын багагүй

хувь нь төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг дэмждэг бол цөөнх нь боловсролын зах зээлийн зарчмыг илүүд үзэж байна. Энэ нь боловсролын бодлогод иргэдийн олон талт хүлээлт байгааг харуулж байна.

Шигтгээ 4

Хүн бүрд боловсрол олгох нь өөрөө Үндсэн хуулиар олгогдсон эрх, эрх чөлөөний нэг. Түүнд төлбөр тогтоож нь өөрөө хүн болгонд боловсрол эзэмших эрхийг хязгаарлаж байгаа үйлдэл гэж харж байна. Боловсролын хувьд эрүүл мэндийн хувьд ч гэсэн ялгаагүй төрийн оролцоо зайлшгүй шаардлагатай.

Фокус бүлгийн ярилцлагын хэсгээс

График 25. Боловсролын үйлчилгээний талаарх байр суурь, улс төрийн үзэл бариимтлалаар



Боловсрол нь нийгмийн бодлогын чухал бүрэлдэхүүн болохын хувьд судалгаанд оролцогчдын талаас илүү хувь нь үнэ төлбөргүй боловсролын тогтолцоог илүүд үзэж байна. Төрөөс санхүүждэг, улсын сургууль давамгайлсан хэлбэр нь иргэдийн хувьд хамгийн зөв сонголт ажээ. Түүний дараагаар либерал үзэл баримтлал бүхий хувийн сургуулиудад өрсөлдөөнт зах зээлийн зарчмаа тогтоож улсын сургуулиудтай хамт боловсролын үйлчилгээ үзүүлнэ гэж үзсэн иргэд 36.7 хувийг бүрдүүлж байна.

Хүний эрхийн талаарх иргэдийн байр суурь

Хүний эрхийн асуудлаас судалгаанд оролцсон иргэдийн дийлэнх хувь нь либерал үзэл баримтлалд хамаарч байлаа. Тус үзүүлэлтийг хэмжихдээ шалгуур үндсэн хоёр асуултаар 0-5 оноогоор үнэлүүлэн хэмжсэн болно. Дараах графикт иргэдийн улс төрийн үзэл баримтлал хийгээд тэдгээр иргэдийн хүний эрхийн асуудлуудад өгсөн онооны дунджийг харууллаа.

График 26. Хүний эрхийн үзүүлэлтийн үнэлгээ (0-5 оноогоор)



Хүний эрх нь нийгмийн аюулгүй байдлаас чухал гэх бодомжид судалгаанд оролцсон иргэдийн дэмжсэн байр суурь харьцангуй өндөр байна. Тэдгээрээс либерал үзэл баримтлалтай иргэд 3.4 оноо өгсөн нь хамгийн өндөр үзүүлэлт болж байна.

Төр хэвлэл мэдээлэл болон нийгмийн сүлжээг хянах ёстой гэх бодомжид иргэдийн санал нийлсэн хувь 2.3 оноо байгаа нь дунджаас бага байна. Тус үзүүлэлтийн хувьд либерал иргэд 1.66 оноог өгсөн нь хамгийн оноо болж байгаа бол социал демократууд 2.95 оноо өгсөн нь өндөр үзүүлэлт болж байна. Үүнээс харахад либералууд тус үзүүлэлт дээр эсрэг байр суурийг түлхүү илэрхийлсэн бол социал демократууд дэмжсэн байдал нь өндөр байгаа ажээ.

График 27. Хүний эрхийн талаарх байр суурь, улс төрийн үзэл бариmтлалаар



Гэр бүлийн талаарх байр суурь

Гэр бүлийн талаарх үндсэн шалгуур асуултад иргэдийн дийлэнх хувь нь буюу 55.5 хувь нь либерал байр суурийг илэрхийлж байлаа. Тус асуултаар гэр бүлийн орчин нь гишүүдийн тэгш эрхийн илэрхийлэл гэж үзэж буй байдал нь давамгай байна.

График 28. Гэр бүлийн амьдралын талаарх байр суурь



График 29. Ижил хүйстний гэрлэлтийн талаарх иргэдийн санал бодол, насны бүлгээр



Ижил хүйстний гэрлэлтийн асуудалд хандах иргэдийн байр суурь насны бүтцээс хамааранд харилцан ялгаатай байна. Тухайлбал судалгаанд оролцогчийн нас залуужих тусам тус асуудалд хандах хандлага эерэг болж байна. Тус үзүүлэлтэд либерал үзэл баримтлалтай иргэд илүүтэй эергээр хүлээж авдаг байна.

Байгаль орчны асуудлаар иргэдийн байр суурь

Байгаль орчин нь хүний нийгэм оршин тогтнох хамгийн материаллаг гол хүчин зүйл болохын хувьд улс төрийн үзэл баримтлалын хувьд ялгаатай авч үздэг. Энэхүү судалгаанд байгаль орчин хийгээд эдийн засгийн асуудлын зохист харьцаан дахь иргэдийн байр суурийг дараах асуултаар тодруулаа.

График 30. Байгаль орчныг хамгаалах бодлогын талаарх байр суурь (хувиар)



Судалгаанд хамрагдсан иргэдийн хоёр хүн тутмын нэг нь “эдийн засгийн өсөлт чухал хэдий ч түүхэн болон үндэсний ач холбогдолтой газруудыг хамгаалахад тэргүүлэх

ач холбогдол өгөх ёстой” хэмээн үзжээ. Манай орны иргэдийн байгальтай харьцах сэтгэлгээнээс үүдэлтэй тус асуудалд хандах хандлага нь консерватив байдал давамгайлдаг ажээ. Харин байгалиас илүүтэй эдийн засгийн өсөлтийг чухалчлах нь зөв гэж үзсэн иргэд хамгийн бага буюу 14.1 хувийг бүрдүүлж байна.

Шигтгээ 5

Судалгаанд оролцогчид эдийн засгийн өсөлт болон байгаль орчноо хамгаалахыг аль алийг нь эн тэнцүү авч үзэх хэрэгтэй гэж үзэж байна. Байгаль орчны асуудлууд тухайлбал ус гол мөрөн бохирдох, ан амьтад устаж үгүй болох зэрэг нь судалгаанд оролцогчдод ихээр ажиглагдах болсон. Байгаль орчны өөрчлөлт нь хүний амьдралд сөргөөр нөлөөлөхүйц хэмжээтэй байгаа тул эдийн засгийн өсөлтийг анхаарахын зэрэгцээ байгаль орчноо орхиж болохгүй гэж үзэх нь элбэг байна.

Фокус бүлгийн ярилцлагын үр дүнгээс

Цагаачлал, галт зэвсгийн асуудлаар иргэдийн байр суурь

График 31. Гаднын улсын иргэдийг хүлээн авах тал дээр иргэдийн байр суурь (хувиар)



Иргэдийн дийлэнх нь үндэсний аюулгүй байдал, ашиг сонирхлыг хамгаалах үүднээс цагаачлалыг хязгаарлах бодлогыг дэмжиж байгаа бол багагүй хэсэг нь үр ашигтай, боловсролтой иргэдийг хүлээн авах нь эдийн засагт эерэг нөлөө үзүүлнэ гэж үзэж байна. Харин гадаадын иргэдийн өргөн цар хүрээтэй нэвтрэлтийг дэмжих байр суурь бага хувийг эзэлж байна.

График 32. Галт зэвсэг эзэмших тал дээр иргэдийн байр суурь (хувиар)



Судалгаанд оролцсон хоёр хүн тутмын нэг нь иргэд галт зэвсгийг чөлөөтэй эзэмших нь нийгэмд аюултай гэж үзэж байна. Харин иргэдэд галт зэвсгийг ялгавартай эзэмшүүлэх хэрэгтэй гэж судалгаанд оролцсон гурван хүн тутмын нэг нь үзсэн байна.

ТАВ. МОНГОЛЫН УЛС ТӨРИЙН НАМУУДЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Монгол Улс хүний эрх, олон ургалч үзлийг дэмждэг, олон намын тогтолцоотой ардчилсан улс бөгөөд 1992 оны Үндсэн хуулиар *иргэд нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам байгуулах, сайн дурааараа эвлэлдэн нэгдэх эрхтэй. Нам нийгэм, төрийн аюулгүй байдлыг сахиж, хуулийг дээдлэн биелүүлнэ*[16], мөн Улс төрийн намын тухай хуулиар *иргэдийн улс төрийн хүсэл зоригийг илэрхийлдэг, улсын хэмжээний бодлого дэвшүүлэн сонгуульд оролцдог, хамтын шийдвэр гаргаж, сайн дурааараа эвлэлдэн нэгдсэн Монгол Улсын иргэдийн нэгдлийг улс төрийн нам*[17] гэж тодорхойлсон.

Өнөөдрийн байдлаар Улсын Дээд шүүхэд 37 улс төрийн нам бүртгэлтэй байгаач тэд ямар үзэл баримтлалтай, үзэл баримтлалаа бодлого, үйл ажиллагаандаа түсгадаг эсэх нь тодорхойгүй, намууд үнэт зүйл, үйл ажиллагаагаараа ялгагдахгүй байна[18] гэж судлаачид дүгнэдэг. Тиймээс энэ өгүүлэл Монголын улс төрийн намууд ямар үзэл баримтлалтай, яагаад үнэт зүйлсээрээ ялгарах ёстой, намын үзэл баримтлал сонгуулийн мөрийн хөтөлбөрт нь хэрхэн туссаныг шинжилж дүгнэхийг зорилоо.

Монголын улс төрийн намуудын үзэл баримтлал

Монгол Улс 1990 онд социалист тогтолцооноос ардчилсан тогтолцоонд шилжсэнээр төрөөс засаглагч намын үзэл суртлыг тулгахаа больж хүний эрх, эрх чөлөө, олон ургалч үзэл, олон намын тогтолцоог зөвшөөрснөөр намууд зэрэгцэн үйл ажиллагаа явуулж, хөгжлийн төлөө олон ургалч бодлогоор уралдуулах болсон. Гэвч улс төрийн намууд сонгосон үзэл баримтлалдаа үнэн ч байгаа эсэх, сонгуулийн мөрийн хөтөлбөрөө үзэл баримтлалдаа тулгуурлан боловсруулсан эсэх нь тодорхойгүй байсаар байна.

Нээлттэй Нийгэм Форумын дэмжлэгтэйгээр ШУТИС-ийн судлаачид “Улс төрийн намын тухай хуулийн шинэчлэлийн зарим асуудал” сэдэвт судалгааг 2021 онд

[16] Монгол Улсын Үндсэн хууль.1992 он. https://legalinfo.mn/mn/detail?lawId=367
[17] Улс төрийн намын тухай хууль (шинэчилсэн найруулга) 2023 он. https://legalinfo.mn/mn/detail?lawId=16760239349461
[18] Ё.Довчин, Г.Цэнд-Аюуш “Улс төрийн үзэл суртал ба намуудын үзэл баримтлал” ПОЛИТОЛОГИ V. Эрдэм шинжилгээний бичиг. № 325 (51)

гүйцэтгэсэн бөгөөд судалгаанд оролцогчдын 65.8 хувь нь намын мөрийн хөтөлбөрийг ямар нэг байдлаар уншдаг гэж хариулсан бөгөөд “Мөрийн хөтөлбөртөө үлгэрийн юм бичдэг, хоосон амлалт өгдөг, бүгд ялгарахгүй ижил мэт санагддаг, хоёр том намын, мөн нэр хүндтэй, олны танил хүний мөрийн хөтөлбөрийг дийлэнхдээ уншдаг” [19] болохыг илрүүлжээ.

Мөн судлаач С.Мөнхбат, Б.Эрдэнэдалай нар 2022 онд “Монголын улс төрийн намын үзэл баримтлал, түүний хэрэгжилтийн зарим асуудал” сэдэвт судалгаагаар улс төрийн намуудын үзэл баримтлалыг иргэд нийт 7 оноогоор үнэлснээс 2.8 оноогоор сонгуульд оролцож буй улс төрийн намуудын мөрийн хөтөлбөр өөр өөрийн онцлог бүхий, ялгаатай байдаггүй, 2.58 оноогоор Монголын улс төрийн намууд үзэл баримтлалын хувьд ялгаатай хөгжиж чадаж байгаа байдал хангалтгүй, 2.23 оноогоор Монголын улс төрийн намуудын үнэт зүйл тодорхой, ойлгомжтой байдаггүй, 2.21 оноогоор улс төрийн намуудын сонгуулийн мөрийн хөтөлбөр үзэл баримтлалтайгаа нийцдэггүй, 2.09 оноогоор сонгогчид улс төрийн намын үзэл баримтлалын дагуу боловсруулагдсан сонгуулийн мөрийн хөтөлбөртэй танилцан сонголтоо хийж чаддаггүй гэж хариулсан нь намууд үзэл баримтлалаа төдийлөн баримтлахгүй, ач холбогдол өгдөггүй болохыг илрүүлжээ.[20] Дээрх судалгаанууд иргэдээр намуудын үзэл баримтлалыг үнэлүүлэхийг зорьсон болохоос нам тус бүр дээр ямар үзэл баримтлалтай, үзэл баримтлал дээрээ тууштай байгаа эсэхийг тодорхойлоогүй байна.

Тиймээс Монголын улс төрийн намууд ямар үзэл баримтлалтай, үзэл баримтлалаа бодлогын баримт бичгүүдээ тусгадаг эсэх, асуудлыг хэрхэн яаж шийдвэрлэхээ судалдаг эсэх, гишүүд, дэмжигчид нь элссэн болон сонгосон намын үзэл баримтлалыг мэддэг эсэх, намууд үзэл баримтлалаа тууштай хэрэгжүүлдэг эсэхийг судаллаа.

Намын түүх, үүсэл, хөгжил

Монгол Улс улс төрийн намын 100 гаруй жилийн түүхийг 2 хувааж болно. Эхний үе нь 1921-1989 он. Энэ үе нь XX зууны эхээр дэлхий даяар улс төрийн үзэл санааны ялгарал явагдаж байх үед буюу 1921 онд Монголчууд тусгаар тогтнол, бүрэн эрхт улс

[19] Я.Төгөлдөр нар “Улс төрийн намын тухай хуулийн шинэчлэлийн зарим асуудал” ШУТИС. ННФ. 2021 он.
[20] С.Мөнхбат, Б.Эрдэнэдалай “Монголын улс төрийн намын үзэл баримтлал, түүний хэрэгжилтийн зарим асуудал” ПОЛИТОЛОГИ XXII. Эрдэм шинжилгээний бичиг №22 (593): 70-81 дэх тал.

байгуулах, харийн дарлалаас чөлөөлөх зорилгоор анхны намыг байгуулсан. Анхны МАН-ыг хожим 1925 онд Монгол Ардын хувьсгалт нам болж нэрээ өөрчилж зүүний нам болж коммунист, социалист үзэл суртлыг тулган хэрэгжүүлдэг байсан. Хоёр дахь нь 1990 оноос хойших үе. Улс төрийн намууд бүгд ардчилсан бөгөөд 1990 оны ардчилал, хүний эрх, эрх чөлөө, чөлөөт нийгмийг байгуулах үзэл санааг дэмждэг. Ямартаа ч намууд ялгаатай үзэл баримтлал, сонгуулийн мөрийн хөтөлбөрөөрөө өрсөлдөж, бодлого, үйл ажиллагаагаараа ялгарахыг хүсдэг, бүсдынхаа үзэл баримтлалд хүндэтгэлтэй ханддаг болсон.

УИХ-д суудалтай намуудын үүсэл, хөгжил

Хүснэгт 9. УИХ-д суудалтай намуудын үүсэл хөгжил

№	Намын нэр	Үүссэн он	Улсын Дээд Шүүхэд бүртгүүлсэн огноо	Нам үүссэн нийгэм, улс төрийн нөхцөл
1	Монгол Ардын Нам (МАН)	1921.03.01	1990.05.16[21]	1921 онд үүссэн. 1990 он хүртэл социалист тогтолцоог бэхжүүлж, нийгэм улс төр, эдийн засаг, соёлын түвшинд коммунист, социалист үзэл суртлыг номлож байсан. 1990 онд олон намын тогтолцоотой ардчилсан тогтолцоог зөвшөөрч улс төрийн олон ургалч үзлийг эш болгож улс төрийн бусад намуудтай зэрэгцэн үйл ажиллагаа явуулж байгаа.
2	Ардчилсан Нам (АН)	1990.04.07	2000.12.26[22]	1990 онд нэг намт социалист тогтолцоог үгүйсгэж гарч ирсэн улс төрийн хөдөлгөөнүүдээс үүссэн. 1990, 1992, 2000 оны улс төрийн намуудын нэгдэл. Монгол Улсад ардчилал, хүний эрх, чөлөөт зах зээлийг бэхжүүлэх зорилготой.
3	Үндэсний эвсэл (Монголын Ногоон Нам, Монголын Үндэсний ардчилсан нам)	1990.03.09	1990.05.26[23]	2024 онд Үндэсний эвсэл байгуулагдсан. Эвслийг 1990 онд үүссэн Монголын Ногоон нам[24], 2006 онд АН-аас салсан Монголын Үндэсний Ардчилсан нам[25]-ууд байгуулсан. Аль аль нь 1990 оны ардчилал, хүний эрх, эрх чөлөөний төлөөх улс төрийн хөдөлгөөнүүдээс үүсэлтэй.
4	Иргэний зориг ногоон нам (ИЗНН)	2000.03.09	2000.03.23[26]	2000 онд МҮАН-аас “С.Зоригийн фракц” гэж нэрлэгдсэн С.Оюун, Ц.Ганхуяг, Т.Эрдэнэбилэг, Х.Хулан, Л.Эрдэнэтуул нарын улс төрчид бие даасан нам байгуулсан түүхтэй.

[21] УДШ-ийн бүртгэл. Монгол Ардын нам. https://www.supremecourt.mn/mn/home?page=party&id=1&pr=63&tp=detail&md=1&h=
[22] УДШ-ийн бүртгэл. Ардчилсан нам. https://www.supremecourt.mn/mn/home?page=party&id=2&pr=63&tp=detail&md=1&h=
[23] УДШ-ийн бүртгэл. Монголын Ногоон нам. https://www.supremecourt.mn/mn/home?page=party&id=3&pr=63&tp=detail&md=1&h=
[24] Иргэний зориг ногоон нам. https://mongoliangreenparty.mn/?p=921
[25] УДШ-ийн бүртгэл. Монголын Үндэсний Ардчилсан нам. https://www.supremecourt.mn/mn/home?page=party&id=13&pr=63&tp=detail&md=1&h=
[26] УДШ-ийн бүртгэл. Иргэний зориг ногоон нам. https://www.supremecourt.mn/mn/home?page=party&id=4&pr=63&tp=detail&md=1&h=

5	ХҮН нам	2011.12.05	2011.12.05[27]	2011 онд Хөдөлмөрийн үндэсний нам социал демократ үзэл баримтлалыг онцолж байгуулагдсан. 2022 онд баруун төвийн үзэл баримтлалтай болж өөрчлөгдсөн.

Намын бодлого, баримт бичиг

Дээд Шүүхэд бүртгэлтэй 37 намын дүрэм нийтэд ил тод биш байгаа учраас намууд ямар үзэл баримтлалтайг нарийвчлан тодорхойлоход бэрхшээлтэй байна. Харин намуудын өөрсдийнх нь өгсөн мэдээлэлд тулгуурлан ямар үзэл баримтлалтайг тодорхойлох боломж байгаа. Гэхдээ энэ нь тухайн намын зорилго, үнэт зүйл нь мөн эсэх, тогтвортой, хүчин төгөлдөр байгаа нь эргэлзээтэй. Тэгэхээр намуудын үзэл баримтлалыг зөвхөн сонгуулийн мөрийн хөтөлбөрөөр тодорхойлох боломж одоогоор байна. Гэсэн ч энэ нь намуудын сонгосон үзэл баримтлалыг буюу үндсэн үнэт зүйл, философийг нь мэдэхгүйгээр намын сонгуулийн мөрийн хөтөлбөрт шинжилгээ хийж, үзэл баримтлалдаа үнэн ч байна уу, тууштай байсан уу гэдгийг тодорхойлох боломжгүй гэдгийг хэлэх ёстой болж байна. Тиймээс УИХ-ын 2024 оны ээлжит сонгуулиар УИХ-д суудалтай болсон МАН, АН, ҮЭ, ИЗНН, ХҮН намуудын албан ёсны баримт бичгүүдэд ямар үзэл баримтлал, үнэт зүйл, эрхэм зорилготойг тодорхойллоо.

Хүснэгт 10. Намуудын эрхэм үзэл бариmтлал, эрх зорилго

№	Намын нэр	Чиг баримжаа	Үзэл баримтлал	Үнэт зүйлс	Эрхэм зорилго
1	Монгол Ардын Нам[28] (МАН)	Зүүн төвийн	Социал демократ	• Эрх чөлөө • Шударга ёс • Эв санааны нэгдэл	Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний язгуур эрх ашгийг эрхэмлэн дээдэлсэн, хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийг бэхжүүлсэн, өмнөх үеийн амжилт бүтээл, өнөө үеийн хичээл зүтгэл, ирээдүй хойч үеийнхээ хүсэл мөрөөдлийг тээсэн сайн сайхан нийгмийг цогцлооно.

[27] УДШ-ийн бүртгэл. ХҮН нам. https://www.supremecourt.mn/mn/home?page=party&id=19&pr=63&tp=detail&md=1&h=

[28] Монгол Ардын намын хөтөлбөр. http://nam.mn/%D0%BD%D0%B0%D0%BC%D1%8B%D0%BD-%D1%85%D3%A9%D1%82%D3%A9%D0%BB%D0%B1%D3%A9%D1%80

2	Ардчилсан Нам (АН)[29]	Баруун төвийн	Либерал	• Хувь хүний эрх чөлөө • Эдийн засгийн эрх чөлөө • Улс төрийн эрх чөлөө • Шударга ёсны эрх чөлөө • Үндэсний эрх чөлөө	Хүн бүр хүсэл мөрөөдөлтэй, өрх бүр аз жаргалтай амьдрах хөгжлийн боломжийг дэмжсэн, иргэд нь эрх чөлөөтэй, эрх тэгш, хариуцлагатай, ардчилсан МОНГОЛ УЛС-ыг цогцлоох.
3	Үндэсний эвсэл[30] (МНН, МҮАН)	Баруун	Либерал, ногоон хөгжил	• Өөртөө итгэлтэй Монголчууд • Саруул ухаанд эрүүл бие • Үйлдвэржилтийн шинэ эрин • Хариуцлагатай засаглал • Эрүүл улс төр, шударга ёс • Ногоон хөгжил	Эх орныхоо язгуур эрх ашгийг эрэмбэлдэг, эвийг сахидаг, иргэдээ хамгаалдаг, өмнөх ажил асуудалдаа өөриймсөг, эрч хүчтэй чадварлаг, шинжлэх ухаанчаар ханддаг, нийгэм нь айдасгүй, амар амгалангаар дүүрэн хүчирхэг Монголоо сэргээн цогцлоох.
4	Иргэний зориг ногоон нам (ИЗНН)[31]	Баруун	Либерал, ногоон үзэл	• Хүний эрх • Ногоон хөгжил • Тогтвортой эдийн засаг	Ардчилал, хүний эрх, чөлөөний үзэл санаанд тулгуурлан, экологийн чиг баримжаатай нийгэм-эдийн засгийн тогтвортой хөгжлийн замд улс орноо хөтөлж, хүн бүр өөрийн хүсэл эрмэлзлээрээ, шударга хөдөлмөрийнхөө үрээр Монголдоо сайхан амьдрах боломжийг бүрдүүлнэ.
5	ХҮН нам[32]	Баруун төвийн	Либерал	• Хүний эрх, эрх чөлөө • Эв нэгдэл • Тэгш боломж • Бүтээх эрх чөлөө • Байгальд ойр Монгол	ХҮН нам нь **Монгол Улсаа** 21-р зууны хөгжлийн шинэ эринд гаргах **их үйлс**ийг түүчээлэх, Эх орондоо **хүмүүнлэг, иргэний, ардчилсан, аз жаргалтай, эрх чөлөөт** нийгмийг байгуулах эрхэм зорилготой, **хүмүүнлэг** эрх чөлөөний үзэл баримтлал бүхий **баруун төв**ийн нам байна.

[29] Ардчилсан намын үзэл баримтлал. http://www.democraticparty.mn/page/19#
[30] Үндэсний эвслийн мөрийн хөтөлбөр. 2024 он. https://gogo.mn/%D0%A3%D0%98%D0%A5-%D1%81%D0%BE%D0%BD%D0%B3%D1%83%D1%83%D0%BB%D1%8C-2024/%D0%BC%D3%A9%D1%80%D0%B8%D0%B9%D0%BD-%D1%85%D3%A9%D1%82%D3%A9%D0%BB%D0%B1%D3%A9%D1%80
[31] Иргэний зориг ногоон нам. https://irgeniizorignogoonnam.mn/
[32] Хүн намын үзэл баримтлал. https://www.hunnam.mn/rules

Ямартаа ч МАН, АН, ИЗНН, ХҮН намуудын хувьд улс төрийн чиг баримжаа нь тодорхой байсан бол ҮЭ-ийн чиг баримжаа нь тодорхойгүй байна. Үзэл суртлын хувьд ҮЭ, ИЗНН, ХҮН намууд яг ямар үзэл суртлыг сонгосон нь тодорхойгүй байсан. Тиймээс намуудын улс төрийн чиг баримжаа, үзэл баримтлал, эрхэм зорилго, үнэт зүйлсийг намуудын цахим хаяг, мөрийн хөтөлбөр, бусад нээлттэй мэдээлэлд үндэслэн тодорхойллоо.

Намууд сонгуулийн мөрийн хөтөлбөрөө үзэл баримтлал дээрээ үндэслэсэн, бодлого, түүний зорилго, хэрэгжих арга зам, эрхзүйн орчин, нөөцийг тодорхойлж тооцоолсон байх учиртай.[33] Дээрх улс төрийн намууд УИХ-ын 2024 оны ээлжит сонгуулийн үеэр сонгогчдод танилцуулсан мөрийн хөтөлбөртөө дараах сонгосон асуудлуудыг хэрхэн томьёолсон, төр ямар оролцоотой байх, яаж хэрэгжүүлэх хэрхэн тооцсоныг судаллаа.

Хүснэгт 11. МАН-ын сонгуулийн мөрийн хөтөлбөр (УИХ-ын 2024 оны ээлжит сонгууль)

№	Үндсэн асуудал	Сонгосон асуудал	Заалтын дугаар	Мөрийн хөтөлбөр дэх заалт	Хэрэгжүүлэх арга зам
1	Эдийн засаг	Иргэнээс авах татварын талаар	2.8.11	Баг орлоготой иргэдийн амьжиргааг дэмжих зорилгоор тансаг хэрэглээнд өндөр, энгийн хэрэглээнд бага татвар ногдуулах тогтолцоог бүрдүүлнэ.	Хэрхэн яаж гэдэг нь тодорхойгүй. Эдийн засгийн тооцоолол байхгүй.
2	Боловсрол	Их, дээд сургуулийн сургалтын чанарыг сайжруулах талаар	1.3.9	Судалгааны их сургууль байгуулж, шинэ мэдлэг бүтээх, технологи үйлдвэрлэх, инновац гаргах, хэрэглээнд нэвтрүүлэх, инновацын эко-системийг бий болгож үр өгөөжтэй технологи боловсруулна.	Хэрхэн яаж гэдэг нь тодорхойгүй. Төр оролцох бололтой.
3	Төр	Төрийн албан хаагчдын тоо	5.3.4	Төрийн захиргааны албан хаагчдын тооны өсөлтийн зохистой харьцааг тогтооно.	Хэрхэн яаж гэдэг нь тодорхойгүй. Тооцоолол байхгүй.
4	Хүний эрх	Иргэний жагсаж, цуглах эрх	4.1.3	Иргэдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хамгаалж, жагсаал, цуглаан хийх зөвшөөрлийн тогтолцоог хална.	Эрх зүйн орчинд өөрчлөлт оруулна.
5	Эрүүл мэнд	Эрүүл мэндийн даатгал	1.2.5	Эрүүл мэндийн даатгалыг багцын системд шилжүүлэн, даатгуулагч өөрт хэрэгтэй багцыг сонгодог тогтолцоонд шилжинэ.	Хэрхэн яаж гэдэг нь тодорхойгүй.
6	Байгаль орчин	Экологийн тэнцвэрийг хадгалах талаар	6.1.6	Байгалийн унаган төрх, биологийн олон янз байдлыг хамгаалж, эко системийн тэнцвэрийг хадгалахад оруулсан иргэн, аж ахуйн нэгжийг урамшуулах тогтолцоог бүрдүүлнэ.	Эрх зүйн орчинд өөрчлөлт оруулна

[33] Д.Бумдарь. Ардчилсан институт ба Монголын ардчиллын тухай эргэцүүлэл: Бид хаана явж байна вэ? Нээлттэй улс төр сэтгүүл. КАС. УБ.,2020. №02. (05)

Хүснэгт 12. АН-ын сонгуулийн мөрийн хөтөлбөр (УИХ-ын 2024 оны ээлжит сонгууль)

№	Үндсэн асуудал	Сонгосон асуудал	Заалтын дугаар	Мөрийн хөтөлбөр дэх заалт	Хэрэгжүүлэх арга зам
1	Эдийн засаг	Иргэнээс авах татварын талаар	5.1.5	Татвар төлөгчийн суурийг өргөжүүлэх замаар төсвийн орлого тогтвортой өсөх нөхцөлийг бүрдүүлнэ.	Хэрхэн яаж гэдэг нь тодорхойгүй. Эдийн засгийн тооцоолол байхгүй.
2	Боловсрол	Их, дээд сургуулийн сургалтын чанарыг сайжруулах талаар	2.1.5.4.	Их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрийн өрсөлдөөнийг нээлттэй болгож, зөвхөн нэг сургуульд тодорхой мэргэжлээр мэргэжилтэн бэлтгэх нөхцөл бүхий давуу байдлыг өөрчилнө.	Төрөөс оролцох бололтой.
3	Төр	Төрийн албан хаагчдын тоо	7.2.6.	Төрийн албаны удирдах албан тушаалтны тоог бууруулж, дарга нарын тансаглахыг таслан зогсооно.	Либерал намын бодлого мөн боловч, ямар ч тооцоолол байхгүй.
4	Хүний эрх	Иргэний жагсаж, цуглах эрх	8.1.1.5.	Иргэд сайн дураар эрхээ шаардан жагсаал, цуглаан хийхэд зөвшөөрөл авдаг байдлыг халж, урьдчилан мэдэгдсэнээр жагсаал, цуглаан хийх эрхийг нээлттэй болгон хуульчилна.	Эрх зүйн орчинд өөрчлөлт оруулна.
5	Эрүүл мэнд	Эрүүл мэндийн даатгал	2.2.6.4.	Өрхийн эрүүл мэндийн төвийн тусламж, үйлчилгээний зардлыг Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлж, тусламж, үйлчилгээний төрлийг нэмэгдүүлнэ.	Тооцоолол байхгүй, хэрхэн энэ зорилтод хүрэх нь ойлгомжгүй. Намын үзэл баримтлалтай нийцэж буй эсэх нь эргэлзээтэй.
6	Байгаль орчин	Экологийн тэнцвэрийг хадгалах талаар	9	Эко системийн тэнцвэрт байдлын алдагдал, байгалийн нөөц баялгийн зүй бус ашиглалтыг зогсоох, цөлжилтийг сааруулах, “ногоон байгаль” бодлогыг хэрэгжүүлэн байгалийн жам ёсоор сэргэх боломжийг дээшлүүлэх замаар хүрээлэн буй орчны тогтвортой байдал, ногоон хөгжлийг дэмжин хүний амьдралын чанарыг сайжруулна.	Хэрхэн хэрэгжүүлэх талаар тодорхой санал, арга, тооцоолол байхгүй.

Хүснэгт 13. Үндэсний эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөр (УИХ-ын 2024 оны ээлжит сонгууль)

№	Үндсэн асуудал	Сонгосон асуудал	Заалтын дугаар	Мөрийн хөтөлбөр дэх заалт	Хэрэгжүүлэх арга зам
1	Эдийн засаг	Иргэнээс авах татварын талаар		Бодит эдийн засгийн загварчлалд суурилан татварын бааз суурийг өргөжүүлж, дагаж мөрдөх зардлыг бууруулахын зэрэгцээ татварын хууль, холбогдох журмуудыг хялбарчлах, татвараас зайлсхийхтэй тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлж, татварын ачааллыг илүү тэгш хуваарилах тогтолцоог боловсронгуй болгон, татварын шинэчлэл хийнэ.	Хэрхэн яаж гэдэг нь тодорхойгүй. Эдийн засгийн тооцоолол байхгүй.
2	Боловсрол	Их, дээд сургуулийн сургалтын чанарыг сайжруулах талаар		Ахисан түвшний сургалт, эрдэм шинжилгээ, инновац, технологийг шинжлэх ухааны паркийн тогтолцоо болон бизнесийн чиг баримжаатай хөгжүүлнэ.	Хэрхэн яаж гэдэг нь тодорхойгүй. Эдийн засгийн тооцоолол байхгүй.
3	Төр	Төрийн албан хаагчдын тоо		Төрийн алба мэргэжлийн, нээлттэй, хариуцлагатай, цомхон байх өөрчлөлтийг орон нутаг, засаг захиргааны нэгжийн шинэчлэлтэй уялдуулан хийнэ.	Хэрхэн яаж гэдэг нь тодорхойгүй.
4	Хүний эрх	Иргэний жагсаж, цуглах эрх		*Энэ талаар заалт байхгүй.*	
5	Эрүүл мэнд	Эрүүл мэндийн даатгал		Аймгуудад хавдрын эмчилгээ, сувилгааны төвүүдийг нэгдсэн эмнэлгүүдийн дэргэд төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулж, үйл ажиллагааны зарим санхүүжилтийг эрүүл мэндийн даатгалтай холбох эрх зүйн орчныг бүрдүүлнэ. Эрүүл мэндийн байгууллагын эмчилгээ, үйлчилгээний зардлыг үр ашигтай хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлж, хувийн эрүүл мэндийн даатгалын тогтолцоог нэвтрүүлнэ. Иргэд улсын эрүүл мэндийн даатгалын сангаас давсан зардлаа хувийн даатгалаас төлүүлдэг болж, гүйцэтгэлийн систем нэвтэрснээр эрүүл хүн, эрүүл мэнддээ анхаардаг иргэн ЭМД-ын сангаас хуримтлал үүсэж, өвчний түүхээ нэгдсэн байдлаар гаргаснаар үр дүнгүй олон шинжилгээ, оношилгоо хийлгэхгүй болгоно.	Хэрхэн яаж гэдэг нь тодорхойгүй. Эдийн засгийн тооцоолол байхгүй. Либерал намын хувьд хувийн даатгалын тогтолцоог оруулах санал нь шинэлэг байна.
6	Байгаль орчин	Экологийн тэнцвэрийг		Хөдөөгийн ногоон хөгжил, экологийн тэнцвэрт байдалтай холбоотой судалгаа, шинжилгээний ажлыг	Хэрхэн яаж гэдэг нь тодорхойгүй.

		хадгалах талаар		дэмжиж, орон нутгийн байгаль орчныг хамгаалах уламжлалт мэдлэг, ур чадварыг сурталчлан таниулах үйл ажиллагааг эрчимжүүлнэ.	

Хүснэгт 14. ИЗНН-ын сонгуулийн мөрийн хөтөлбөр (УИХ-ын 2024 оны ээлжит сонгууль)

№	Үндсэн асуудал	Жишээ болгож авсан асуудал	заалтын дугаар	Мөрийн хөтөлбөр дэх заалт	Хэрэгжүүлэх арга зам
1	Эдийн засаг	Иргэнээс авах татварын талаар		*Энэ талаар заалт байхгүй.*	
2	Боловсрол	Их, дээд сургуулийн сургалтын чанарыг сайжруулах талаар	2.3.6 2.3.9 2.3.10	Шинжлэх ухааны салбар, шинжлэх ухааны бүтээгдэхүүний инновацыг хөхүүлэн дэмжиж ажиллах, шинжлэх ухааны салбарт зарцуулдаг төсвийг нэмэгдүүлнэ. 18-25 насны их дээд сургууль, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд суралцаж буй оюутнуудын цагийн ажлын цалин хөлсөөр суутгах зарим төрлийн татвар хураамжийг чөлөөлөх эрх зүйн орчныг бүрдүүлнэ. Сургууль, боловсролын хөтөлбөрийг дэмжихэд төсвийн илүү хувийг хуваарилж, боловсролын салбарт төвийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх хүчин чармайлт гаргана.	Либерал намын суурь үнэт зүйлтэй нь нийцэж буй нь эргэлзээтэй. Төрийн дэмжлэг, хөрөнгө оруулалтаар энэ бодлого хэрэгжих бололтой.
3	Төр	Төрийн албан хаагчдын тоо		*Энэ талаар заалт байхгүй.*	
4	Хүний эрх	Иргэний жагсаж, цуглах эрх	1.2.2	Үг хэлэх, цугларах, хэвлэн нийтлэх эрх чөлөөг хамгаалах, сэтгүүлчдийг айлган сүрдүүлэх, цензурээс айлгүйгээр үйл ажиллагаа явуулах эрх зүйн боломжоор хангана.	Либерал намын бодлого мөн. Эрх зүйн орчныг өөрчлөх юм байна.
5	Эрүүл мэнд	Эрүүл мэндийн даатгал	2.4.8 2.4.9	Монгол улсын төсөв дэх эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн	Либерал намын үнэт зүйлд нийцэх үү. Төрийн оролцоог

				хэмжээг тодорхой хувиар нэмэгдүүлэх бодлого баримтална. Төрөөс хариуцан төлж буй иргэний эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг дундаж хувьд ойртуулна.	нэмэгдүүлэх юм байна.
6	Байгаль орчин	Экологийн тэнцвэрийг хадгалах талаар	4.5.7	Байгаль хамгаалах уламжлалт зан үйл, ёс заншил, мэдлэг, хууль цаазад тулгуурлан иргэдийн экологийн ёс зүйн боловсролыг дээшлүүлэх, зөв хандлага, дадлыг бий болгохыг дэмжинэ.	Төрөөс аядуу бодлого явуулах юм байна.

Хүснэгт 15. ХҮН намын сонгуулийн мөрийн хөтөлбөр (УИХ-ын 2024 оны ээлжит сонгууль)

№	Үндсэн асуудал	Сонгосон асуудал	Заалтын дугаар	Мөрийн хөтөлбөр дэх заалт	Хэрэгжүүлэх арга зам
1	Эдийн засаг	Иргэнээс авах татварын талаар		*Энэ талаар заалт байхгүй.*	
2	Боловсрол	Их, дээд сургуулийн сургалтын чанарыг сайжруулах талаар	2.1	Төрийн өмчит их сургуулиудын удирдлага, хяналтын тогтолцоо, засаглалыг улс төрөөс ангид болгон профессорт суурилсан, хувийн компаниудтай эрүүл хамтын ажиллагаатай байх, Инновацад суурилсан их сургуулиудыг бий болгоно. Сургалтын их сургуулиас судалгааны их сургууль гэсэн хөгжлийн концепцыг хэрэгжүүлнэ.	Либерал намын бодлого мөн. төрийн оролцоог бууруулах, бизнесийн зарчмаар хөгжих боломжийг олгох юм байна. Гэхдээ нарийн тооцоо, арга нь тодорхойгүй байна.
3	Төр	Төрийн албан хаагчдын тоо	3	Төрийн албыг улс төрийн нам, улс төрчдийн нөлөөлөл, дарамтаас ангижруулан, бүтэц зохион байгуулалтын хувьд оновчтой болгож орон тоог боломжит доод хэмжээнд хүртэл бууруулан бүтээмжийг нэмэгдүүлэх цогц арга хэмжээ авч хэрэгжүүлнэ. Энэ хүрээнд яамдын тоог арваас хэтрүүлэхгүй байх бодлогыг баримталж, агентлагуудыг тоог өнөөгийнхөөс гурав дахин цөөлөн, чиг үүргийг нь яамдад хариуцуулах замаар төсвийн хэмнэлтийг бий болгож, цомхон төрийн зарчмыг баримтална.	Либерал намын бодлогод нийцэж болно. Гэхдээ хэрхэн, яаж гэдэг нь тодорхойгүй байна.
4	Хүний эрх	Иргэний жагсаж, цуглах эрх	3	Иргэдийн улс төрийн эрх, эрх чөлөөг бүрэн хангах баталгааг бүрдүүлэх ба үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн	Либерал намын бодлого мөн. Эрх

				нийтлэх, тайван замаар жагсах, цуглах эрхээ эдэлсний төлөө хууль бусаар мөрдөн хавчигддаг, үндэслэлгүйгээр хууль зүйн хариуцлагад татагдах явдлыг эцэс болгоно.	зүйн орчныг өөрчлөх юм байна.
5	Эрүүл мэнд	Эрүүл мэндийн даатгал	2.2	Эмнэлгийн тусламж үйлчилгээ, төлбөрөөс хамаарч эдийн засгийн дарамтад орох эрсдэлээс иргэдийг хамгаалах үүднээс эрүүл мэндийн салбарт хувийн даатгалын тогтолцоог нэвтрүүлж, даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэн даатгуулагчид очих өгөөжийг нэмэгдүүлнэ. Эрүүл мэндийн даатгалын тогтолцооны бие даасан хараат бус байдлыг бэхжүүлнэ.	Либерал намын бодлого мөн. хэрхэн яаж гэдэг нь тодорхойгүй байна.
6	Байгаль орчин	Экологийн тэнцвэрийг хадгалах талаар	4	Ойжуулалт, нөхөн сэргээлт, тогтвортой газар тариалан эрхлэх, газрын тогтвортой менежментийн сайн туршлагыг нэвтрүүлнэ. Эвдэрсэн газрыг сэргээх, хөдөө аж ахуйн арга техникийг хэрэгжүүлэх, нүүрс төрөгчийг шингээх, экосистемийн уян хатан чанарыг нэмэгдүүлэхийн тулд хөрс, газрыг хамгаалах хүчин чармайлтыг дэмжинэ.	Хэрхэн яаж гэдэг нь тодорхойгүй.

УИХ-д суудалтай МАН, АН, ҮЭ, ИЗНН, ХҮН намуудын УИХ-ын 2024 оны ээлжит сонгуульд дэвшүүлсэн мөрийн хөтөлбөрт дээрх 6 асуудлаар шинжилж үзэхэд дараах нийтлэг зүйлс ажиглагдлаа. Үүнд:

1. Улс төрийн намууд өөрсдийн үзэл баримтлал, үнэт зүйл, зарчим, эрхэм зорилгодоо нийцсэн мөрийн хөтөлбөр боловсруулсан эсэх нь эргэлзээтэй байна.
2. Намуудын сонгуулийн мөрийн мөрийн хөтөлбөрт дэвшүүлсэн асуудлуудад онцын ялгаа ажиглагдахгүй байна.
3. Намууд сонгуулийн мөрийн хөтөлбөр боловсруулахдаа хэрхэн яаж, энэ асуудлыг шийдвэрлэх, уг асуудлыг шийдвэрлэхэд ямар нөөцийг ашиглах, юм үр дүнд хүрэх талаар ямар ч тооцоолол гаргаагүй байна. Өөрөөр хэлбэл судалгаанд суурилж, намынхаа үзэл баримтлалд хэрхэн яаж асуудлыг шийдэх, арга тооцооллоо сонгуулийн мөрийн хөтөлбөртөө тусгаагүй байна.

Намын үйл ажиллагаа болон гишүүдийн байр суурь

Өмнөх хэсгүүдэд Монголд нам үүссэн гадаад дотоод нийгэм, улс төр, эдийн засгийн нөхцөл болон намууд ямар үзэл баримтлалыг сонгосон, бодлого, баримт бичигт хэрхэн тусгасныг УИХ-д суудалтай намуудын жишээн дээр нээлттэй мэдээллийг ашиглаж тодорхойлсон. Харин намын үзэл баримтлалыг бодитойгоор хэрэгждэг эсэхийг энэ хэсэгт тодорхойлох юм. Үүнийг намын дарга, удирдлага, гишүүдийн ойлголт, ил хэлсэн үгс, ярилцлагууд, мөн намын улс төрийн шийдвэрүүд болон түүний хэрэгжилтээр тухайн нам үзэл баримтлалдаа тууштай байж чадаж байгаа эсэхийг тодорхойлох боломжтой.

Гэхдээ энэ судалгаа нь зөвхөн УИХ-ын 2024 оны ээлжит сонгуулиар УИХ-д суудалтай болсон МАН, АН, ҮЭ, ИЗНН, ХҮН намуудын мөрийн хөтөлбөрийг дүгнэх цаг хугацаа хараахан болоогүй байна. Дараагийн УИХ-ын ээлжит сонгуулийн өмнө дүгнэх боломж бүрдэх байх.

Өнөөдрийн байдлаар УИХ-ын 126 суудлын 68-ыг авсан МАН, 42-ыг авсан АН, 8 суудалтай ХҮН намууд эвсэж “Хурдтай хөгжлийн төлөөх зориг” хамтарсан засгийн газрыг 2024 оны 8 дугаар сард байгуулсан. Онолын хувьд баруун, зүүний намууд эвсэх ямар ч боломжгүй. Эвсэж болох ганцхан үндэслэл нь УИХ-д аль нэг нам олонх болоогүй тохиолдол. Гэвч ийм тохиолдол үүсээгүй. Тэгэхээр барууны намууд зүүн талаа хашааг давсан уу, эвсэл зүүний нам баруун талын хашааг давуу гэдэг нь цаашид намуудын үзэл баримтлалыг судлахад онцгой судлагдахуун болох байх. Ямартаа ч намуудын үзэл баримтлал, сонгуулийн үеэр зарлаж байсан мөрийн хөтөлбөр, саналаа өгсөн сонгогчдын дэмжлэг, итгэл үнэмшил хаана байна вэ.

Түүхийг сөхөж харвал либерал нам хүүхдийн мөнгө, үндэсний тэтгэлэг зарлаж байсан, тэрийгээ одоо ч гавьяа гэж дүгнэдэг, намууд тооцоо судалгаагүй мөнгө амлаж байсан, сонгуулийн үеэр сонгогчдод намынхаа үзэл баримтлалын үүднээс хэрхэн яаж мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлэхээ хэзээ ч тайлбарлаж байгаагүй.

Харин 2024 оны УИХ-ын ээлжит сонгуулийн үеэр намуудын дунд анх удаа бодлогын мэтгэлцээн зохион байгуулахад сонгуульд оролцсон 19 нам, 2 эвсэл намынхаа үзэл баримтлалын үүднээс бодлогоор мэтгэлцэж чадаагүй. Цаашид намууд намууд

өөрсдийн сонгосон үзэл баримтлал дээрээ тулгуурлаж, тооцоо шинжилгээтэй мэтгэлцэж сурах байх.

Засаглалыг хэрэгжүүлсэн улс төрийн намууд сонгууль бүрийн өмнө засгийн газрын мөрийн хөтөлбөр маш сайн биелсэн гэж дүгнэдэг. Энэ нь сонгогчдод нөлөөлөх улс төрийн манупуляци. Үнэндээ энэ дүгнэлтийг эрх баригч нам өөрөө бус, хөндлөнгийн хараат бус судалгааны байгууллага, иргэд дүгнэх ёстой.

Цогц хөгжлийн үндэсний төвийн 2024 оны Иргэдийн улс төрийн үзэл баримтлалын зураглал, улс төрийн идэвх оролцоо, ойлголт, мэдлэгийг тодорхойлох судалгаагаар судалгаанд хамрагдсан намын гишүүд ямар үзэл баримтлалыг чухалчилдгыг МАН, АН, ХҮН намын гишүүдээр харахад МАН-ын гишүүдийн 32.2 хувь нь социал демократ үзэл баримтлал, АН-ын гишүүдийн 16.1 хувь нь либерал үзэл баримтлал, ХҮН намын гишүүдийн 58.3 хувь нь либерал үзэл баримтлалтай байгаа нь намынхаа үзэл баримтлалтай нийцэж байна. Бусад нь өөрсдийгөө тухайн намын гишүүн гэж хариулсан ч өөр үзэл баримтлалтай байх магадлалтай байна. Мөн МАН, АН, ХҮН намыг иргэд улс төрийн үзэл баримтлалын хувьд хэрхэн хардаг болохыг судлахад МАН-ыг иргэдийн 32.2 хувь нь социал демократ үзэлтэй, АН-ыг дөрвөн хүн тутмын нэг нь буюу 25.6 хувь нь либерал үзэл баримтлалтай, ХҮН намыг 13.6 хувь нь либерал үзэл баримтлалтай гэж зөв хариулжээ. Бусад нь нам ямар үзэл баримтлалтайг мэдэхгүй байна. Өөрөөр хэлбэл, иргэд улс төрийн намуудын үзэл баримтлалын талаарх мэдээлэл харьцангуй бага, иргэдийн талаас илүү нь улс төрийн намын үзэл баримтлалын талаар мэдээлэл байдаггүй болох нь харагдаж байна.

Анхнаасаа намууд ямар үзэл баримтлалтайг сайн мэдэхгүй, ихэнх намын улс төрийн чиг хандлага тодорхойгүй байгаа нь иргэдийн буруу огтоос биш. Харин улс төрийн намууд иргэдэд улс төрийн боловсрол олгодоггүй өнөөг хүрсэнтэй холбоотой. Тиймээс цаашид намууд үзэл баримтлалаа зарлах, сонгуулийн мөрийн хөтөлбөртөө тусгах, хэрэгжүүлэх арга зам, тооцооллоор өрсөлддөг болох, иргэд, судалгаачид, судалгааны хараат бус байгууллагууд намыг үнэт зүйл, үзэл баримтлалдаа тууштай байхыг шаардах улс төрийн соёлыг төлөвшүүлэх шаардлага байсаар байна.

ДҮГНЭЛТ

Судалгаанд хамрагдсан иргэдийн 34.2 хувь нь **социал демократ**, 31.2 хувь нь **консерватив**, 22.2 хувь нь **либерал** давамгайлсан улс төрийн үзэл баримтлалтай байгаа бол 12.5 хувь нь аль нэг тал давамгайлсан бус улс төрийн үзэл баримтлалын холимог шинж чанарыг агуулсан байна. Харин судалгаанд оролцогчдоос өөрийн үзэл баримтлалыг хэрхэн тодорхойлж байгааг тодруулахад 52.5 хувь өөрсдийн тодорхойлж мэдэхгүй байлаа. Үүнээс харахад сонгуулийн насны иргэд улс төрийн үзэл баримтлалаа тодорхойлох мэдлэг, ойлголт сул бөгөөд шалгуур асуултаар тодорхойлсон улс төрийн үзэл баримтлалтайгаа нийцэх нь тун бага хувийг бүрдүүлж байна. Улс төрийн үзэл баримтлал нь улс төрийн үйл ажиллагаа, бодлого боловсруулахад суурь үндэс болдог хэдий ч иргэдийн хувьд улс төрийн үзэл баримтлалын талаар тогтсон ойлголт хараахан бүрдээгүй байна. Иргэдийн улс төрийн үзэл баримтлал нь хатуу тогтсон гэхээсээ илүүтэй прагматик байдлаар улс төрийн үйл явдалд хандаж байна

Иргэдийн улс төрийн үзэл баримтлалыг тодорхойлохдоо үндсэн долоон хэмжигдэхүүн (төрийн зохион байгуулалт, эдийн засаг, нийгмийн бодлого, хүний эрх, гэр бүл, байгаль орчин), түүнд хамаарах 12 дэд хэмжигдэхүүний хүрээнд шалгуур асуултаар иргэдийн улс төрийн үзэл баримтлалыг тодорхойлсон. Нийгмийн голлон институтүүдийн хувьд иргэдийн улс төрийн үзэл баримтлалын чиг баримжаа харилцан ялгаатай байна. Монголчууд төрийн зохион байгуулалт, эдийн засгийн асуудлаар консерватив үзэл баримтлал давамгайлдаг бол нийгмийн бодлого буюу боловсрол эрүүл мэндийн асуудлаар социал демократ чиг баримжаа баримтлах нь нийтлэг буюу тус салбар дахь төрийн оролцоо, зохион байгуулалт зайлшгүй шаардлагатай гэж үзэх нь нийтлэг байна. Харин хүний эрх болон гэр бүлийн асуудлаар либерал үзэл баримтлал бүхий чиг баримжаа давамгайлж байна. Түүний дараагаар уг судалгааны үдсэн үзүүлэлт болох байгаль орчны асуудлаарх иргэдийн хандлага болон цагаачлал галт зэвсэг эзэмших талаарх асуудлаар иргэдийн дунд консерватив үзэл баримтлал түлхүү давамгайлж байна. Үүнээс харахад иргэд дээрх бүх асуудлаар нэгдсэн нэг улс төрийн үзэл баримтлалд хамаарах байр суурийг баримтлах нь цөөн бөгөөд асуудал тус бүрээр ялгаатай байр суурийг баримталж байгаа нь судалгаанаас харагдаж байна.

Иргэдийн улс төрийн үзэл баримтлал нь ихэвчлэн эдийн засгийн байдалтай холбоотой байдал судалгааны явцад ажиглагдлаа. Тухайлбал иргэд эдийн засгийн өсөлтийг дэмжих буюу чөлөөт зах зээл, хувийн хэвшлийг хөгжүүлэх шаардлагатай гэж үзэхийн зэрэгцээ эдийн засгийн хямрал, ажилгүйдэлтэй холбоотойгоор төрийн зохицуулалт, халамжийг нэмэгдүүлэхийг дэмжих хандлага бодитой байна. Товчоор хэлбэл иргэд эдийн засгийн эрх чөлөөг дэмждэг боловч нийгмийн тэгш байдлыг чухалчилж байна.

Улс төрийн намууд сонгогчдын үзэл бодлыг хураах, бодлого руу сонгогчдын саналыг татахад үзэл баримтлал чухал үүрэгтэй. Мэдээж сонгогчдын санаа бодлыг нэгтгэх, дэмжлэг авахад ямар үзэл баримтлалтай байх, тэрийгээ олон нийтэд хэрхэн таниулах, сонгуулийн мөрийн хөтөлбөртөө тусгах, тууштай байх нь намын төлөвшилд, сонгогчдын боловсрол, улс төрийн соёлд нэн тустай.

Улс төрийн намууд сонгогчдын үзэл бодлыг хураах, бодлого руу сонгогчдын саналыг татахад үзэл баримтлал чухал үүрэгтэй. Мэдээж сонгогчдын санаа бодлыг нэгтгэх, дэмжлэг авахад ямар үзэл баримтлалтай байх, тэрийгээ олон нийтэд хэрхэн таниулах, сонгуулийн мөрийн хөтөлбөртөө тусгах, тууштай байх нь намын төлөвшилд, сонгогчдын боловсрол, улс төрийн соёлд нэн тустай.

Өнгөрсөн 35 жилийн хугацаанд Монголын улс төрийн намууд ямар үзэл баримтлалтай байсан, түүнийгээ хэрхэн бодлого, баримт бичигтээ тусгадаг, намуудын үйл ажиллагаа, улс төрийн шийдвэр нь үзэл баримтлал, мөрийн хөтөлбөртөө нийцдэг эсэхийг судалсан судалгаа байхгүй байна. Тиймээс энэхүү судалгаагаар дараах дүгнэлтийг хийлээ.

1. Дээд Шүүхэд бүртгэлтэй 37 намын дүрэм нийтэд ил тод биш байгаа нь намууд ямар үзэл баримтлалтайг нарийвчлан тодорхойлоход хүндрэл учруулж байна. Цаашид эрх бүхий байгууллагууд бүх намын дүрмийг нийтэд ил тод болгох хэрэгтэй.
2. УИХ-ын 2024 оны ээлжит сонгуулиар УИХ-д суудалтай болсон МАН, АН, ҮЭ, ИЗНН, ХҮН намуудын албан ёсны баримт бичгүүдийг судлахад намуудын улс төрийн чиг баримжаа нь тодорхой байна. Харин ҮЭ, ИЗНН, ХҮН намууд яг ямар үзэл суртлыг сонгосон нь дүрэм, мөрийн хөтөлбөрт тодорхойгүй байсан. Тиймээс намууд ямар чиг баримжаатай, ямар үзэр суртлыг чухалчилж байгаа, өөрсдийн улс төрийн зорилгоо илүү тодорхой зарлах хэрэгтэй байна.

3. Монголын улс төрийн намууд өөрсдийн үзэл баримтлал, үнэт зүйл, зарчим, эрхэм зорилгодоо нийцсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр боловсруулсан эсэх нь эргэлзээтэй байна. Намуудын дүрэм, үзэл сурталаа тодорхой болгочихвэл сонгуулийн мөрийн хөтөлбөр нь уялдаатай эсэхийг тодорхойлох боломж бүрдэнэ.
4. Намуудын сонгуулийн мөрийн мөрийн хөтөлбөрт дэвшүүлсэн асуудалд онцын ялгаа ажиглагдахгүй, хийх ажлын бүлэглэсэн жагсаалт байна. Цаашид улс төрийн намууд бодлогын нам болохын тулд яаж хэрэгжүүлэхээрээ ялгардаг улс төрийн соёлд суралцах хэрэгтэй байна.
5. Намууд сонгуулийн мөрийн хөтөлбөр боловсруулахдаа хэрхэн яаж, энэ асуудлыг шийдвэрлэх, уг асуудлыг шийдвэрлэхэд ямар нөөцийг ашиглах, ямар үр дүнд хүрэх талаар ямар ч тооцоо, судалгаа хийгээгүй байна. Өөрөөр хэлбэл судалгаанд суурилж сонгуулийн мөрийн хөтөлбөрөө боловсруулаагүй байна. Цаашид баруун, зүүний намууд намууд төрийн оролцоо их эсвэл бага, хүний эрх, эрх чөлөө нээх, эсвэл хязгаарлах, эдийн засагт төрийн оролцоо нэмэх, эсвэл бууруулах, иргэдээс авах татварыг нэмэх, эсвэл багасгах зэрэгт анхаарсан суурь судалгаатай мөрийн хөтөлбөрөө боловсруулах хэрэгтэй байна.

Намуудын үзэл баримтлал тодорхойгүй байгаа нь намыг бодлогын институц болж төлөвшихөөс гадна сонгогчдын улс төрийн боловсрол, хандлага төлөвшиж саад болж байна. Тиймээс цаашид намууд үзэл баримтлалаа зарлах, сонгуулийн мөрийн хөтөлбөрөө үзэл баримтлал дээрээ тулгуурлаж боловсруулах, хэрхэн хэрэгжүүлэх арга зам, тооцооллоор өрсөлддөг, мэтгэлцдэг болох, мөн үнэт зүйл, үзэл баримтлалдаа тууштай байх нь Монголд ардчилал бэхжих, олон намын тогтолцоо төлөвшихөд тустай.

НОМ ЗҮЙ

1. Political spectrum. https://www.britannica.com/topic/political-spectrum
2. Britannica encyclopedia. https://www.britannica.com/topic/political-party
3. Идеологи.https://mn.wikipedia.org/wiki/%D0%98%D0%B4%D0%B5%D0%BE%D0%BB%D0%BE%D0%B3%D0%B8
4. Andrew Heywood. Introduction to Politics. 2005
5. Mannheim, Karl. Ideology and Utopia: An Introduction to the Sociology of Knowledge. Harcourt, 1936.
6. Gramsci, Antonio. Quaderni del carcere. 1929
7. Eyerman, Ron. False Consciousness and Ideology in Marxist Theory. Acta Sociologica, vol. 24, no. 1/2, 1981, pp. 43–56.
8. Burke, Edmund. Reflections on the French Revolution. 1790
9. Locke, John. Two Treatises of Government. Awnsham Churchill, 1689.
10. Mill, John Stuart. On Liberty. J.W. Parker and Son, 1859.
11. Hayek, Friedrich A. The Road to Serfdom. University of Chicago Press, 1944;
12. Hayek, Friedrich A. Law, Legislation, and Liberty: Rules and Order. University of Chicago Press, 1973.
13. Friedman, Milton. Capitalism and Freedom. University of Chicago Press, 1962.
14. Rand, Ayn. The Virtue of Selfishness. Signet, 1964.
15. CIVICUS Monitor, People Power Under Attack, 2024. https://monitor.civicus.org/globalfindings_2024/
16. Andrew Heywood. Introduction to Politics. 2005
17. Монгол Улсын Үндсэн хууль.1992 он. https://legalinfo.mn/mn/detail?lawId=367
18. Улс төрийн намын тухай хууль (шинэчилсэн найруулга) 2023 он. https://legalinfo.mn/mn/detail?lawId=16760239349461
19. Ё.Довчин, Г.Цэнд-Аюуш “Улс төрийн үзэл суртал ба намуудын үзэл баримтлал” ПОЛИТОЛОГИ V. Эрдэм шинжилгээний бичиг. № 325(51)
20. Д.Бумдарь. Ардчилсан институт ба Монголын ардчиллын тухай эргэцүүлэл: Бид хаана явж байна вэ? Нээлттэй улс төр сэтгүүл. КАС. УБ.,2020. №02. (05)
21. Я.Төгөлдөр нар “Улс төрийн намын тухай хуулийн шинэчлэлийн зарим асуудал” ШУТИС. ННФ. 2021 он.
22. Н.Отгонбаяр. “Орчин үеийн улс төрийн үзэл суртлын чиг хандлага” Нээлттэй улс төр сэтгүүл. КАС. УБ.,2020. №02. (05)
23. С.Мөнхбат, Б.Эрдэнэдалай “Монголын улс төрийн намын үзэл баримтлал, түүний хэрэгжилтийн зарим асуудал” ПОЛИТОЛОГИ XXII. Эрдэм шинжилгээний бичиг №22 (593): 70-81 дэх тал.
24. УДШ-ийн улс төрийн намын бүртгэл. https://www.supremecourt.mn/mn/home?page=party&id=69&pr=63&tp=list
25. Бүгд найрамдахчуудын олон улсын хүрээлэн, Эмэгтэйчүүд, залуучуудын улс төрийн оролцоонд тулгарч буй саад бэрхшээлийн тухай, 2021 он.

26. Иргэний зориг ногоон нам. https://mongoliangreenparty.mn/?p=921
27. Монгол Ардын намын хөтөлбөр. http://nam.mn/%D0%BD%D0%B0%D0%BC%D1%8B%D0%BD-%D1%85%D3%A9%D1%82%D3%A9%D0%BB%D0%B1%D3%A9%D1%80
28. Ардчилсан намын үзэл баримтлал. http://www.democraticparty.mn/page/19#
29. Үндэсний эвслийн мөрийн хөтөлбөр. 2024 он. https://gogo.mn/%D0%A3%D0%98%D0%A5-%D1%81%D0%BE%D0%BD%D0%B3%D1%83%D1%83%D0%BB%D1%8C-2024/%D0%BC%D3%A9%D1%80%D0%B8%D0%B9%D0%BD-%D1%85%D3%A9%D1%82%D3%A9%D0%BB%D0%B1%D3%A9%D1%80
30. Иргэний зориг ногоон нам. https://irgeniizorignogoonnam.mn/
31. Хүн намын үзэл баримтлал. https://www.hunnam.mn/rules
32. Britannica encyclopedia. https://www.britannica.com/topic/political-party
33. Идеологи. https://mn.wikipedia.org/

Хавсралт

Иргэдийн улс төрийн үзэл баримтлал, идэвх оролцоо, ойлголт мэдлэгийг тодорхойлох судалгааны асуулт

Судалгаанд оролцогчийн ерөнхий мэдээлэл

1. Таны хүйс
    a. Эрэгтэй
    b. Эмэгтэй
2. Таны нас
    a. 18–19
    b. 20–24
    c. 25-29
    d. 30-34
    e. 35-39
    f. 40-44
    g. 45-49
    h. 50-54
    i. 55-59
    j. 60-64
    k. 65-69
    l. 70+
3. Та хаана амьдардаг вэ?
    a. Улаанбаатар хотод
    b. Аймгийн төвд
    c. Сумын төвд
    d. Хөдөө
4. Таны боловсрол?
    a. Боловсролгүй
    b. Бага
    c. Дунд
    d. Бүрэн дүнд
    e. Тусгай дүнд
    f. Бакалавр/Дээд
    g. Магистр болон түүнээс дээш
5. Та улс төрийн мэдээллийг түлхүү хаанаас авдаг вэ?
    a. Телевиз
    b. Мэдээллийн сайт
    c. Сошиал медиа (фэйсбүүк, твиттер... гм)
    d. Сонин, сэтгүүл
    e. Гэр бүл, найз нөхөд
    f. Бусад

6. Таны ажил эрхэлдэг салбар? *(Зөвхөн нэг хариулт сонгоно уу)*

a. Төрийн захиргааны байгууллага
b. Төрийн үйлчилгээний байгууллага
c. Төрийн тусгай алба
d. Төрийн өмчит үйлдвэрийн газар
e. Хувийн компанид
f. Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч
g. Хувираа үйлчилгээ, худалдаа эрхэлдэг
h. Төрийн бус байгууллага
i. Олон улсын байгууллага
j. Оюутан, сурагч
k. Тэтгэвэр, групп
l. Ажилгүй
m. Малчин
n. Бусад

6. Таны сарын орлогын хэмжээ ойролцоогоор хэдэн төгрөг вэ? *(Цалин, тэтгэвэр, тэтгэмж гэх мэт бүх орлого орно)*
   a. *0-660,000*
   b. 660,001-1,000,000
   c. 1,000,001-2,000,000
   d. 2,000,001-3,000,000
   e. 3,000,001-4,000,000
   f. 4,000,000-с дээш
   g. Хариулахаас татгалзсан /Уншихгүй/

7. Та өөрийгөө нийгмийн аль давхаргад хамаарна гэж үзэж байна вэ?
   a. Дээд
   b. Дундаас дээгүүр
   c. Дунд давхарга
   d. Дундаас доогуур
   e. Доод
   f. Мэдэхгүй/ хариулаагүй (энэ хариултыг уншихгүй)

Иргэдийн улс төрийн үзэл баримтлал

Төр, засаг

8. Таны бодлоор төр засаг өмчтэй, үйлдвэртэй байх ёстой юу? *(Зөвхөн нэг хариулт сонгоно)*
   a. Төр засаг аль болохоор өөрийн гэсэн өмч хөрөнгөтэй, үйлдвэртэй байх хэрэгтэй
   b. Төр аль болох өмч хөрөнгө, үйлдвэртэй байх хэрэггүй, Зах зээлийн зарчмаар хувийн хэвшилд даатгах ёстой.
   c. Төр засаг үндэсний ашиг сонирхол, стратегийн хувьд өмч, үйлдвэртэй байж болно

Эдийн засгийн бодлого

9. Таны бодлоор төр эдийн засагт ямар байдлаар оролцох ёстой вэ? *(Зөвхөн нэг хариулт сонгоно)*
    a. Төр эдийн засгийг зохицуулах ёстой, Шударга ёс, тэгш байдлыг хангахын тулд
    b. Төр оролцох ёсгүй, Хувийн хэвшилд бүрэн даатгах ёстой.
    c. Төр засаг үндэсний ашиг сонирхол, хөгжил дэвшлийн төлөө өөрийн зах зээлийг хамгаалахаас бусдаар оролцохгүй

10. Таны бодлоор төр засаг нийгмийн баялгийн талаар ямар үүрэг хүлээх нь зүйтэй вэ? *(Зөвхөн нэг хариулт сонгоно)*
    a. Нийгмийн баялгийг боломж тааруу ядуу хэсэгт хуваарилах хэрэгтэй
    b. Нийгмийн баялгийг бүх хүмүүс өөр өөрийн ажил хөдөлмөр эрхлэхэд нь дэмжихэд зориулах хэрэгтэй
    c. Нийгмийн баялгийг эдийн засгийн өсөлт, үйлдвэржилтэд зарцуулах ёстой
11. Засгийн газар баялгийг тэгш хуваарилах үүрэгтэй юу? *(0 бол огт санал нийлэхгүй, 5 бол бүрэн санал нийлнэ. 0-ээс 5 хүртэлх үнэлгээ өгнө үү")*

0	1	2	3	4	5

Нийгмийн бодлого

12. Та эрүүл мэндийн үйлчилгээний талаар ямар байр суурьтай байдаг вэ? *(Зөвхөн нэг хариулт сонгоно)*
    a. Эрүүл мэндийн үйлчилгээ бүх нийтэд үнэ төлбөргүй, төрийн өмч давамгайлсан байх ёстой
    b. Эрүүл мэндийн үйлчилгээ зах зээлийн зарчмаар үнэ төлбөртэй явагдаж, хувийн хэвшил давамгайлах ёстой
    c. Эрүүл мэндийн тогтолцоонд хэн сайн даатгагдаж хамгаалагдсан нь илүү сайн үйлчилгээ авах ёстой

13. Та боловсролын үйлчилгээний талаар ямар байр суурьтай байдаг вэ? *(Зөвхөн нэг хариулт сонгоно)*
    a. Ерөнхий боловсрол үнэ төлбөргүй, төрөөс санхүүждэг улсын сургуулиуд давамгай байх ёстой
    b. Боловсролын үйлчилгээг улсын болон хувийн сургууль хамтдаа үзүүлнэ. Хувийн сургуулиуд өрсөлдөөнт зах зээлийн зарчмаар төлбөрөө тогтооно.
    c. Төр зөвхөн үндсэн стандарт тогтоож, хязгаарлагдмал санхүүжилт үзүүлэх хэрэгтэй. Хувийн сургуулиуд давамгайлах ёстой.

Хувь хүний эрх чөлөө ба төрийн хяналт

14. “Хувь хүний эрх нийгмийн аюулгүй байдлаас илүү чухал” гэдэгтэй Та санал нийлэх үү? *(0 бол огт санал нийлэхгүй, 5 бол бүрэн санал нийлнэ. 0-ээс 5 хүртэлх үнэлгээ өгнө үү”)*

0	1	2	3	4	5

15. “Төр хэвлэл мэдээлэл болон нийгмийн сүлжээг хянах ёстой” гэдэгтэй Та санал нийлэх үү? *(0 бол огт санал нийлэхгүй, 5 бол бүрэн санал нийлнэ. 0-ээс 5 хүртэлх үнэлгээ өгнө үү”)*

0	1	2	3	4	5

16. Дараах асуудлуудад Монгол Улсын Засгийн газар хэр их ач холбогдол өгөх ёстой вэ? *(Маш бага ач холбогдол өгөх ёстой бол 0, маш их ач холбогдол өгөх ёстой бол 5, 0-ээс 5 хүртэлх оноо өгнө үү)*

	0	1	2	3	4	5
Ажилгүйдлийг бууруулах						
Дундаж давхаргыг тэлэх						
Байгаль орчныг хамгаалах						
Монголын өв, соёлыг хамгаалах, түгээн дэлгэрүүлэх						
Үндэсний аюулгүй байдлыг бэхжүүлэх						
Боловсрол болон эрүүл мэндийн үйлчилгээг хүртээмжтэй болгох						
Жендерийн эрх тэгш байдлыг хангах						

Гэр бүл, иргэний нийгэм

17. Хүний эрхийн талаарх Таны байр суурь ямар байдаг вэ? *(Зөвхөн нэг хариулт сонгоно)*
    a. Хүмүүсийн хувийн орон зай, хөндлөнгөөс оролцохгүй, албадахгүй байх гэж ойлгодог
    b. Хүмүүс ямар нэг үйл ажиллагаа явуулах боломж, нөхцөлөөр хангагдах, бусдаас үл хараат байх явдал гэж ойлгодог
    c. Хүмүүс өөр өөрсдийн эрх, үүргээ сайн мэдэж, хэрэгжүүлж байх явдал гэж боддог
18. Гэр бүлийн амьдралын талаар та ямар байр суурь баримталдаг вэ? *(Зөвхөн нэг хариулт сонгоно)*
    a. Гэр бүлийн амьдрал эхнэр, нөхөр, гишүүдийн эрх чөлөө, хувийн орон зай, хамгааллын орон зай байх ёстой
    b. Гэр бүлийн амьдрал эхнэр, нөхөр, гишүүдийн тэгш эрхийн илэрхийлэл байх учиртай

c. Гэр бүлийн амьдрал эр нөхөр нь гэр бүлээ тэжээж, эхнэр нь ар гэр, үр хүүхдээ асарч авч явах нь зүйтэй

19. Орчин үеийн нийгэм дэх гэрлэлтийн талаарх таны байр суурь ямар байна вэ? Ижил хүйстэй хүмүүс гэрлэх нь хэвийн зүйл гэдэгтэй санал нийлэх үү? *(Зөвхөн нэг хариулт сонгоно)*
    a. Тийм
    b. Үгүй
20. Хамтран амьдрагч, эсвэл ганц бие амьдрах, гэр бүлээс гадуур хүүхэд төрүүлэх нь ердийн үзэгдэл гэдэгтэй санал нийлэх үү? *(Зөвхөн нэг хариулт сонгоно)*
    a. Тийм
    b. Үгүй
21. Буу галт зэвсэг эзэмших асуудлын талаар та ямар бодолтой явдаг вэ? *(Зөвхөн нэг хариулт сонгоно)*
    a. Хүн бүр өөрсдийн болон гэр бүлийн аюулгүй байдлын төлөө эзэмшиж болно
    b. Хүмүүс галт зэвсгийг чөлөөтэй эзэмших нь нийгэмд аюултай
    c. Хүмүүст галт зэвсгийг ялгавартай эзэмшүүлэх хэрэгтэй

Байгаль орчин

22. Байгаль орчныг хамгаалах бодлогыг хэрхэн хэрэгжүүлэх ёстой вэ? *(Зөвхөн нэг хариулт сонгоно)*
    a. Байгаль орчин нь нийгмийн тогтвортой хөгжлийн үндэс, улс орны ирээдүй тул байгалийг хамгаалж, хатуу зохицуулалт тогтоох ёстой.
    b. Нэн тэргүүнд эдийн засгийн өсөлт чухал байна. Байгаль орчныг хамгаалахын түлд эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлж болохгүй.
    c. Эдийн засгийн өсөлт чухал хэдий ч түүхэн болон үндэсний ач холбогдолтой газруудыг хамгаалахад тэргүүлэх ач холбогдол өгөх ёстой.
23. Цаг агаарын өөрчлөлт, дэлхийн дулаарал гэж ярих болсон. Та энэ талаар ямар байр суурьтай байдаг вэ? *(Зөвхөн нэг хариулт сонгоно)*
    a. Дулааны цахилгаан станц буюу нүүрс түлдэг эрчим хүчний үйлдвэрлэлээс яаралтай татгалзах, сэргээгдэх эрчим хүчийг ашиглах хэрэгтэй
    b. Нүүрс түлдэг эрчим хүчний үйлдвэрлэл нь хамгийн зөв сонголт
    c. Аль алийг нь хослуулсан өөрийн онцлогт тохирсон эрчим хүчний үйлдвэрлэлийг нэвтрүүлэх нь зөв

Цагаачлал

24. Гадаадын иргэдийн Монгол улсад цагаачлуулах талаар та ямар байр суурьтай явдаг вэ? *(Зөвхөн нэг хариулт сонгоно)*
    a. Гаднын улсын иргэдийг хүлээн авч, олон соёлт нийгмийг хөгжүүлэхийг дэмжих хэрэгтэй. Төрөөс цагаачдыг дасан зохицох, нийгэмд оролцоотой байх хөтөлбөрийг дэмжих ёстой.
    b. Ур чадвартай, боловсролтой хүмүүсийг цагаачлуулан авч, эдийн засгийн өсөлтийг дэмжих хэрэгтэй.
    c. Цагаачдыг хүлээн авах нь үндэсний аюулгүй байдалд эрсдэл учруулах эрсдэлтэй. Цагаачлалын бодлого хатуу байж үндэсний ашиг сонирхлыг хамгаалах ёстой.

Улс төрийн тогтолцоо

25. “Ардчилал бол хамгийн оновчтой засаглалын хэлбэр” гэдэгтэй Та санал нийлэх үү? *(0 бол огт санал нийлэхгүй, 5 бол бүрэн санал нийлнэ. 0-ээс 5 хүртэлх үнэлгээ өгнө үү”)*

0	1	2	3	4	5

26. “Автократ буюу нэг хүний засаглал улс орны хөгжлийг түргэсгэж чадна” гэдэгтэй Та санал нийлэх үү? *(0 бол огт санал нийлэхгүй, 5 бол бүрэн санал нийлнэ. 0-ээс 5 хүртэлх үнэлгээ өгнө үү”)*

0	1	2	3	4	5

27. Монгол Улсын хөгжилд аль тогтолцоо тохиромжтой гэж үзж байна вэ? *(Зөвхөн нэг хариулт сонгоно)*

    a. Бие даасан төлөөллийн байгууллага болох Парламентын тогтолцоо

    b. Хүчтэй удирдагч бүхий Ерөнхийлөгчийн тогтолцоо

    c. Аль аль нь биш

    d. Хэлж мэдэхгүй байна

УЛС ТӨРИЙН ОРОЛЦОО

28. Та 2024 оны УИХ-ын сонгуульд саналаа өгсөн үү? *(Зөвхөн нэг хариулт сонгоно)*
    a. Тийм
    b. Үгүй

29. Та 2024 оны Орон нутгийн сонгуульд саналаа өгсөн үү? *(Зөвхөн нэг хариулт сонгоно)*
    a. Тийм
    b. Үгүй

Ерөнхий улс төрийн чиг баримжаа

30. **Та өөрийгөө улс төрийн аль үзэл баримтлалд хамааруулах вэ?**
    a. Либерал
    b. Социаль демократ
    c. Консерватив
    d. Либертар
    e. Дэвшилтэт буюу прогрессив
    f. Бусад
    g. Хэлж мэдэхгүй байна

31. Танд дэмждэг улс төрийн нам байгаа юу? *(Зөвхөн нэг хариулт сонгоно)*
    a. Байхгүй
    b. МАН
    c. АН
    d. ХҮН нам
    e. ИЗНН
    f. Үндэсний эвсэл
    g. Үнэн ба зөв
    h. Бусад.....

32. Та сонгууль өгөхдөө дэмжиж буй намынхаа улс төрийн үзэл баримтлалыг хэр зэрэг харгалзан үзэж саналаа өгсөн бэ? *(0 бол огт харгалзаж үзээгүй, 5 бол Бүрэн харгалзаж үзсэн. 0-ээс 5 хүртэлх оноо өгнө үү)*

0	1	2	3	4	5

33. Та дараах улс төрийн намуудыг ямар үзэл баримтлалтай гэж боддог вэ? (Мөр бүрд зөвхөн нэг хариулт сонгоно уу)

1	Монгол Ардын Нам	1. Социал демократ 2. Либерал 3. Консерватив 4. Хэлж мэдэхгүй байна
2	Ардчилсан Нам	1. Социал демократ 2. Либерал 3. Консерватив 4. Хэлж мэдэхгүй байна
4	Хөдөлмөрийн Үндэсний Нам	1. Социал демократ 2. Либерал 3. Консерватив 4. Хэлж мэдэхгүй байна

34. Та улс төрийн намын гишүүнчлэлтэй юу? Тийм бол аль нам бэ? *(Зөвхөн нэг хариулт сонгоно)*
    a. Үгүй, гишүүнчлэлгүй
    b. МАН
    c. АН
    d. Хүн
    e. ИЗНН
    f. Ногоон нам
    g. Үнэн ба зөв
    h. ИОНН
    i. Бусад

35. Хэрэв гишүүн биш бол Танд улс төрийн намд элсэх бодол байгаа юу? *(Зөвхөн нэг хариулт сонгоно)*

a. Тийм
b. Үгүй

36. **Та өөрийн улс төрийн талаарх мэдлэг ойлголтоо хэрхэн дүгнэх вэ? *(0 бол маш муу, 10 бол маш сайн. 0-ээс 10 хүртэлх үнэлгээ өгнө үү)***

0					10

37. Монголын улс төрийн намууд өөрсдийн үзэл баримтлалаа иргэдэд тодорхой танилцуулж чаддаг уу? ***(0 бол огт үгүй, 5 бол маш сайн. 0-ээс 5 хүртэлх үнэлгээ өгнө үү)***

0	1	2	3	4	5

38. Монголын улс төрийн намууд өөрсдийн тунхагласан үзэл баримтлалдаа үнэнч байж хэрэгжүүлж буй бодлого, мөрийн хөтөлбөртөө үзэл баримтлалаа тусгаж чаддаг уу? ***(0 бол огт үгүй, 5 бол маш сайн. 0-ээс 5 хүртэлх үнэлгээ өгнө үү)***

0	1	2	3	4	5

39. Та өөрийгөө улс төрийн амьдрал дахь үйл явдал, шийдвэрүүдийн талаар мэдээлэл хэр зэрэг авдаг гэж хэлэх вэ? ***(0 бол огт мэдээлэл авдаггүй, 5 бол маш сайн мэдээлэл авдаг. 0-ээс 5 хүртэлх үнэлгээ өгнө үү)***

0	1	2	3	4	5

40. Та хувь хүнийхээ тухайд тулгамдаж байгаа асуудлаа (ажилд орох, орлогоо сайжруулах гэх мэт өөрөөс шалтгаалах асуудлаар) шийдвэрлүүлэхийн тулд хаана хандвал үр дүнтэй гэж бодож байна вэ? (Зөвхөн нэг хариулт сонгоно уу)

a) Улс төрийн нам
b) Улсын Их Хурал
c) Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
d) Бусад
e) Хэлж мэдэхгүй байна

41. Та амьдарч буй орчиндоо тулгамдаж буй асуудлаа (зам, барилга, хог хаягдал гэх мэт) шийдвэрлүүлэхийн тулд хаана хандвал оновчтой гэж бодож байна вэ? (Зөвхөн нэг хариулт сонгоно уу)

a) Улс төрийн нам
b) Улсын Их Хурал
c) Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
d) Бусад
e) Хэлж мэдэхгүй байна

42. Та аливаа асуудлаар хууль эрх зүйн хувьд буруу, ялгавартай шийдвэр гаргаж байна гэж үзвэл тухайн асуудлыг хаана хандаж шийдвэрлүүлэх боломжтой гэж бодож байна вэ? (Зөвхөн нэг хариулт сонгоно уу)

a) Улс төрийн нам
b) Улсын Их Хурал
c) Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
d) Бүсад
e) Хэлж мэдэхгүй байна